

المجلة و استعراض الحرف  
و الف ٤٥٤٤ الف حرفة الحرف  
المجلة حرفة الف حرفة حرفة



# АГУУЛГА

---

ӨМНӨХ ҮГ

2022 ОНЫ ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

- 01** УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА 9
- 02** УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА 23
- 03** УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМ ШИЛЖИЛТЭД ШИЛЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА 45
- 04** УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ПАРЛАМЕНТАД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА 53
- 05** ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ 65
- 06** УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА 75
- 07** ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА 89



## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т заасны дагуу толилуулж байна.

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газар нь Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах хуульд заасан чиг үүрэг, Улсын Их Хурал, Тамгын газрын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудаа амжилттай хэрэгжүүлээ.

Өнгөрөгч он Улсын Их Хурал хууль тогтоох үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангах, бүтээмжийг нэмэгдүүлэх, хяналт шалгалтын бүрэн эрхээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, парламентын цахим шилжилтийг гүнзгийрүүлэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх, хууль тогтоох дээд байгууллага хоорондын гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлд онцлох ололтод хүрсэн жил байлаа.

2022 онд Улсын Их Хурлаар 557 хууль, 84 тогтоол батлуулсан нь өнгөрсөн онтой харьцуулахад 23 хувь өсчээ. Нэгдсэн хуралдааны тоо өмнөх оноос 5.5, Байнгын, дэд, түр хороодын хуралдааны тоо 8.3 хувиар нэмэгдсэн бөгөөд Байнгын, дэд, түр

хорооноос баталсан тогтоол 30.3, санал, дүгнэлт, танилцуулга 1.5 хувь өссөн байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд шинэ хуулийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, парламентын хяналтын шинэ механизмыг зөв төлөвшүүлэн тогтоох Улсын Их Хурлын шинэчлэлийн зорилтыг хэрэгжүүлэхэд Тамгын газрын зүгээс онцгойлон анхаарч ажиллалаа.

Тайлант хугацаанд Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, Хүний эмийн чанар, Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх зэрэг асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хороод байгуулагдан ажиллаж, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг тал бүрээс нь шинжлэн судалж, бодит мэдээллийг ард түмэнд ил тод болгон, иргэдийн мэдэх эрхийг хангасан. Тамгын газрын зүгээс эдгээр ажилд мэргэжлийн болон техникийн туслалцаа үзүүлж, ажлын алба байгуулах, хянан шалгах шинжээчдийг татан оролцуулах, холбогдох төсөв хөрөнгийг хуульд заасны дагуу шийдвэрлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зэргээр туслалцаа үзүүлж ажиллав.

Шинэ хуулийн дагуу 40 түр хороо, ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 313 гишүүн ажилласан нь өмнөх





## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

# 2022 ОНЫ

## ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ



### **1. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАВ.**

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг 2021 онд баталж, 2022 оны нэгдүгээр сараас эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Тус хуулийн дагуу энэ онд хуулийн биелэлт, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар Улсын Их Хурал хянан шалгах 3 Түр хороо байгуулж, ажиллав.



### **2. ЦАХИМ ПАРЛАМЕНТЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ШАТ АХИЖ, “D-PARLIAMENT” СИСТЕМИЙГ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЛЭЭ.**

Улсын Их Хурал D-Parliament вэб болон аппликэйшн хосолсон цахим системийг 2022 оны 04 дүгээр сард албан ёсоор хэрэглээнд нэвтрүүллээ. Тус системээр дамжуулан иргэд, олон нийт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон боловсруулалтын шатанд байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд санал өгөх, цахим санал асуулга зохион байгуулах, санал хүсэлтээ цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч шууд илэрхийлэх нөхцөл боломж бүрдлээ.



### **3. “АРД ТҮМЭН ЗАСАГЛАХ” ЭРХИЙГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДҮҮЛЭВ.**

Монгол Улсын Үндсэн хуульд заасан ард түмэн засаглах эрхийг хангах шинэчлэлийн зорилгын хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орлоо.

Уг өөрчлөлтийн дагуу иргэд тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар асуулт асуух, санал өгөх эрхээ Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас, гарутас, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан программ хангамжаар дамжуулан хэрэгжүүлэх боломж бүрдлээ. Үүний үр дүнд тодорхой асуудлаар Ажлын хэсэг байгуулах саналыг 33.000 ба түүнээс дээш тооны иргэн, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах саналыг 70.000 ба түүнээс дээш тооны иргэн, хуулийн төслийн талаарх саналыг 100.000 ба түүнээс дээш тооны иргэн тус тус дэмжсэн бол Улсын Их Хурал холбогдох хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэхээр болсон юм.



### **4. “ТӨСӨВ-2023” ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ АНХ УДАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА.**

Монгол Улсын түүхэнд анх удаа улсын төсвийн төслөө ард олон, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагууд, ажил олгогчид хамтран ярилцаж, шүүн тунгаах зорилгоор “Төсөв 2023” олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хуулийн төсөлд иргэд, олон нийтээс 10 хоногийн хугацаанд 798 санал ирүүлснээс 302 буюу 37.8 хувийг D-Parliament цахим системээр дамжуулан ирүүлсэн. Иргэд, олон нийтээс ирүүлсэн эдгээр саналуудыг нээлттэй хэлэлцүүлгийн үрдүнтэй нэгтгэж, Төсвийн тухай хуулийн төсөлд тусган, шийдвэрлэсэн нь улсын төсөв хэлэлцэх шинэ жишиг тогтоолоо.



### **5. ПАРЛАМЕНТЫН МЭРГЭШСЭН АЖЛЫН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ЦОГЦ БОДЛОГО ХЭРЭГЖЛЭЭ.**

Парламентын сургалтын цогц хөтөлбөрт тусгагдсан 30 хөтөлбөрөөс 13 сургалтын дэд хөтөлбөрийг боловсруулж, баталсан нь Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг урагшлуулахад чухал нөлөө үзүүлэв. Тухайлбал, Хуулийн төсөл боловсруулагчдыг бэлтгэх сургалтын хөтөлбөр, гарын авлага, Хүний эрхэд суурилсан хандлага сургалтын хөтөлбөр, Жендэрийн мэдрэмж сургалтын хөтөлбөр зэргийг боловсруулж, баталснаар сургалтын агуулгыг шинэ шатанд гаргалаа.



### **6. МОНГОЛ УЛСАД АРДЧИЛСАН ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДСАНЫ 30 ЖИЛ, АНХНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН 30 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭВ.**

Үндсэн хуулийн нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, ололт, амжилтыг бататган бэхжүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, эрхэмлэн дээдлэх ухамсар соёлыг төлөвшүүлэх зорилгоор 1992 оны Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлээ. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлыг сонгох анхдугаар сонгуулиар байгуулагдсан 1992-1996 оны Улсын Их Хурлын Монгол төрийн болон парламентын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдлыг парламент байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд тодотгон авч үзэж, тэмдэглэн өнгөрүүлэв.



## **7. “ПАРЛАМЕНТЫН БОЛОВСРОЛ” ХӨТӨЛБӨР ХҮРЭЭГЭЭ ТЭЛЖ, ПАРЛАМЕНТЫН МЭТГЭЛЦЭЭНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЭХЛЭЛ ТАВИГДАВ.**

Улсын Их Хурлын Тамгын газар “Парламентын боловсрол” хөтөлбөрөөр дамжуулан иргэд, хүүхэд залууст ардчилал, хүний эрх, Үндсэн хуульт болон парламентад ёсны мэдлэг, боловсрол олгох ажлыг 2021 оноос эхлүүлсэн. 2022 онд тус хөтөлбөрийн хүрээнд Баян-Өлгий, Ховд, Увс аймагт сургалт зохион байгуулж, Баянхонгор, Өвөрхангай аймагт “Хууль тогтоомж сурталчлах төв” байгуулахаар болов. Түүнчлэн Ерөнхий боловсролын 62 сургуулийн 102 багшийг “Парламентын боловсролын сургагч багш”-аар бэлтгэж, сурагчдын дунд парламентын мэтгэлцээний тэмцээнийг үндэсний хэмжээнд 2022 оны тавдугаар сард зохион байгуулав.



## **8. УЛСЫН ИХ ХУРАЛ, ТАМГЫН ГАЗРЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРГӨЖЛӨӨ.**

“КОВИД 19” цар тахлын улмаас тодорхой хэмжээнд хязгаарлагдмал байсан Улсын Их Хурлын гадаад арга хэмжээ идэвхтэй өрнөв. Швейцарь, Франц, БНСУ зэрэг улс орны парламентуудтай хамтран ажиллах чиглэлийг тодорхой болгож, “хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр хариуцсан нэгж”-тэй болов. Улсын Их Хурал ОУПХ-той хамтран ажиллах Санамж бичиг байгууллаа. Улсын Их Хурлын Тамгын газрын болон Улсын Их Хурлын даргын ажлын алба, Улсын Их Хурал дахь намын бүлгийн Ажлын албаны 81 албан хаагчид гадаад улсын парламент, олон улсын байгууллагуудад ажиллав.



## **9. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГОТой БОЛОВ.**

Улсын Их Хурлын Тамгын газар 2022 онд байгууллагын эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын төлөвшлийг шинэ шатанд гаргах бодлогын зорилт дэвшүүлсний үр дүнд “Улсын Их Хурлын Тамгын газрын Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг батлан хэрэгжүүлж эхэллээ. Эрсдэлийн удирдлагын бодлого нь Улсын Их Хурлын Тамгын газраас хууль тогтоомжид заасан эрхлэх ажил, чиг үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдах, хариу арга хэмжээ авахад баримтлах зарчим, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон урт хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичиг юм.



## **10. ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН БАТЛАХ ШААРДЛАГАТАЙ ДҮРЭМ, ЖУРМУУДЫГ ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТЛАВ.**

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу 2020 онд 4, 2021 онд 20, 2022 онд 23 нийт 47 дүрэм, журмыг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн баталж, хэрэгжүүлснээр Тамгын газрын үйл ажиллагаа шинэ хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй хэрэгжиж байна.







## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



### I БҮЛЭГ

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

- 1.1. Хууль тогтоох үйл ажиллагааны чиглэлээр
- 1.2. Хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр
- 1.3. Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр
- 1.4. Дүгнэлт, зорилт

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

## 1.1. ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 76 удаа 365 цаг 06 минут, Байнгын, дэд, түр хороо 288 удаа (үүнээс Байнгын хороод 253, дэд хороод 11, түр хороод 24 удаа) 477 цаг 02 минут хуралдаж, 1093 (давхардсан тоогоор) асуудал хэлэлцсэн байна.

Байнгын болон дэд, түр хорооны 146 тогтоол батлагдсан ба олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц зөвшилцөх 10,

хэлэлцэх эсэх 81, анхны хэлэлцүүлгийн 99, зөвшилцөх 9, соёрхон батлах 5, холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн 74, бусад асуудлаар 50 санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлгийн 54 танилцуулга, анхны хэлэлцүүлгийн 1407 (үүнээс дэмжигдсэн 1358, дэмжигдээгүй 59), эцсийн хэлэлцүүлгийн 143 зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлээ

### НЭГДСЭН ХУРАЛДААНД ОРУУЛАН ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАРИМТ БИЧГИЙН ТОО

Хэлэлцэх эсэхийн санал, дүгнэлт

81

Эцсийн хэлэлцүүлгийн танилцуулга

54

Соёрхон батлах санал, дүгнэлт

5

ОУ-ын гэрээ, хэлэлцээр, конвенцын зөвшилцөх санал, дүгнэлт

10

Анхны хэлэлцүүлгийн санал, дүгнэлт

99

УИХ-тай урьдчилан зөвшилцсөн санал, дүгнэлт

9

Бусад асуудлаарх санал, дүгнэлт

50

Холбогдох байнгын хороонд хүргүүлсэн санал, дүгнэлт

74

Тамгын газар 557 хууль, 84 тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн, Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлснээс анхдагч хууль 24, олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах

тухай хууль 4, хуулийн шинэчилсэн найруулга 9, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 510, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 10, Улсын Их Хурлын 84 тогтоолыг тус тус батлуулжээ.

2022 онд батлуулсан хууль, тогтоол 2021 оныхтой харьцуулахад 23 хувиар нэмэгдсэн.



76

НЭГДСЭН ХУРАЛДААН



365

ЦАГ 06 МИНУТ



288

БАЙНГЫН, ДЭД, ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН



477

ЦАГ 02 МИНУТ

1093

ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТОО

## БАТАЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ



Тамгын газар Улсын Их Хурлын гишүүдийн хүсэлтээр 13 хуулийн төсөл, 2 тогтоолын төсөл, хамт өргөн мэдүүлэх 12 хуулийн төсөл, 7 төслийн үзэл баримтлал, 7 танилцуулгыг боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлж, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Монгол Улсын сонгуулийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн агуулгаар Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлттэй холбогдуулан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн 8 тайлбарын төсөл боловсруулан албажуулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх 105 хууль, тогтоолын (үүнээс 82 хууль, 23 тогтоол) бүрдүүлбэрийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хянаж, 7 хууль, тогтоолын төслийг хуульд заасан шаардлагыг хангуулав.

Улсын Их Хурлын даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 52 дугаар захирамжаар баталсан "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга бэлтгэх, хянах журам"-ын дагуу Улсын Их Хурлаас баталсан 788 хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг хянаж, нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх, найруулгын болон дэс дараалал, бүтцийн зэрэг хууль зүйн техникийн засварыг хийж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах ажлыг зохион байгууллаа.



567

2022 онд анхдагч 29 хууль, шинэчилсэн найруулга, олон улсын гэрээ соёрхон батлах тухай 4 хууль, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 446 хууль, хууль хүчингүй болсонд тооцох тухай 8 хууль, Улсын Их Хурлын 80 тогтоолыг хууль тогтоомжийн санд бүртгэн, баяжилт хийж хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хяналтын эх хувьд (цаасан) байршуулж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас [www.parliament.mn](http://www.parliament.mn), дотоод сүлжээ болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудаст байршуулсан.



556

157

Улсын Их Хурлын Тамгын газрын хууль тогтоомжийн санд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 135 зарлиг, Ерөнхий сайдын 1 захирамж, Засгийн газрын 416 тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2 дүгнэлт, 2 тогтоолыг нэмж оруулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүд, байгууллага, иргэд, Улсын Их Хурлын Тамгын газрын болон Улсын Их Хурал дахь намын бүлгийн ажилтнуудыг 157 удаа лавлагаа, мэдээллээр хангав.



19,668

29,680

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 365 цаг 06 минутын явцын талаар 1205 хуудас товч болон 6159 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл, 13,509 хуудас хавсралт баримт бичгийн хамт нийт 19,668 хуудас, Байнгын, дэд, түр, хянан шалгах түр хороодын хуралдааны 477 цаг 02 минутын явцын талаарх 1484 хуудас товч болон 8528 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс буулган бичиж, хянан, хэвлэж, нийт 10,012 хуудас, бүгд 29,680 хуудас хуралдааны тэмдэглэл, баримт материалыг бүрдүүлж, хүлээлгэн өгөв.

### Чуулганы нэгдсэн хуралдаан



365

цаг 06 минут



6159

дэлгэрэнгүй тэмдэглэл



13,509

хавсралт баримт бичиг

### Байнгын хороодын хуралдаан



477

цаг 02 минут



1484

товч тэмдэглэл



8528

дэлгэрэнгүй тэмдэглэл

### Хууль зүйн дүгнэлт гаргах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх талаар

7 хуулийн төсөлд эрх зүйн дүгнэлт гаргаж, холбогдох Байнгын хороодод хүргүүлэв.

**Үүнд:**

Д/д	Хууль тогтоомжийн төслийн нэр	Байнгын хороо
1.	Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл	АБГББХ
2.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	ЭЗБХ
3.	Зөвшөөрлийн тухай хуулийн нэгтгэсэн төсөл	ЭЗБХ
4.	Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	ХЗБХ
5.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	
6.	"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл	ҮББХ
7.	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	ТББХ

## Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэх чиглэлээр

Улсын Их Хурал, Олон Улсын Парламентын холбоо хооронд хүний эрх, жендэрийн асуудлаар хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр солилцов.



Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа болон түүний бүтэц, үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг дэмжих, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тунхагласан.

Уг санамж бичгийн хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Парламент болон хүний эрхийн үндэсний байгууллагууд хоорондын харилцааны тухай Белградын зарчмууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



*“Парламент болон хүний эрхийн үндэсний байгууллагууд хоорондын харилцааны тухай Белградын зарчмууд” хэлэлцүүлэг*

Тамгын газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг батлав. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр Монгол Улсад парламентын ардчиллыг

бэхжүүлэх, парламент дахь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой баталсан хууль тогтоомжууд, өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд хүний эрхийн дүн шинжилгээ хийх боломж бүрдэх юм.



## 1.2. ХУРАЛДААНЫ ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, хуралдааны тэмдэглэлийг цаг тухайд нь гаргаж албажуулан ажиллав.

Улсын Их Хурлын чуулганы 76 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын 253, дэд хороодын 11, түр хороодын 8, Хянан шалгах түр хороодын 16 хуралдааны бэлтгэлийг хангаж хуралдуулсан байна.



Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан **76** удаа, **365** цаг **06** минут


Байнгын хорооны хуралдаан **253** удаа, **418** цаг **16** минут

Дэд хорооны хуралдаан **11** удаа, **19** цаг **13** минут

Түр хорооны хуралдаан **24** удаа, **26** цаг **33** минут

### ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААН

### 76 удаа



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийн дагуу болон үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан чуулганы нэгдсэн

хуралдааныг 3 удаа цахим хэлбэрээр хуралдуулсан бөгөөд 73 удаа “Их хуралдай” танхимд нэгдсэн байдлаар, нийт 76 удаа зохион байгуулсан байна.


### Нэгдсэн хуралдааны тоо, цаг, хэлэлцсэн асуудал

Д/д	Чуулган	Хэлэлцсэн асуудлын тоо	Хуралдсан тоо	Хуралдсан цаг
1.	2021 оны намрын ээлжит чуулган (2022.01.06-2022.01.18)	25	4	24:44
2.	Хүндэтгэлийн хуралдаан (2022.01.13)	1	1	0:30
3.	2022 оны ээлжит бус чуулган (2022.01.28-2022.01.31)	13	2	5:16
4.	2022 оны хаврын ээлжит чуулган (2022.03.15-2022.07.06)	201	37	191:47
5.	2022 оны ээлжит бус чуулган (2022.08.22-2022.08.30)	19	6	11:18
6.	Хүндэтгэлийн хуралдаан (2022.11.24)	1	1	0:40
7.	2022 оны намрын ээлжит чуулган (2022.10.03-2022.12.31)	122	25	130:51
<b>Нийт</b>		<b>382</b>	<b>76</b>	<b>365:06</b>

### Байнгын хороодын хуралдаан

Байнгын хороодын нэр	2021 оны найрмын ээлжит чуулган /2022.01.02-2022.01.16/	2022 оны 01 дүгээр сар	2022 оны ээлжит бус чуулган /2022.01.28-2022.01.31/	2022 оны хаврын ээлжит чуулган /2022.03.15-2022.07.06/	2022 оны ээлжит бус чуулган /2022.08.22-2022.08.30/	2022 оны найрмын ээлжит чуулган /2022.10.06-2022.12.31/	Нийт хуралдааны тоо
АБГББХ	1	-	1	12	2	12	28
БОХХААБХ	1	-	1	12	2	8	24
БСШУСБХ	0	-	1	5	2	4	13
ЁЗСХБХ	0	-	1	4	1	1	7
ИЦББХ	0	-	1	3	1	3	8
НББХ	2	-	1	11	1	7	22
ТББХ	3	-	1	15	5	7	31
ТБХ	0	-	3	14	1	9	27
ҮББХ	0	1	1	9	1	7	19
ХЗБХ	2	-	1	18	1	12	34
ЭЗБХ	3	-	1	19	2	13	38
ХАМТАРСАН	0	-	0	2	0	0	2
НИЙТ: 12	13	1	13	124	19	83	253

### Дэд хороодын хуралдаан:



## Түр хороодын хуралдаан

№	Түр хороодын нэр	Хуралдааны тоо
1.	Түр хороо (Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий)	3
2.	Түр хороо (Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн)	1
3.	Түр хороо ("Оюутолгой ордны ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий)	1
4.	Түр хороо (Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих)	3
<b>Нийт</b>		<b>8</b>

№	Хянан шалгах түр хороодын нэр	Хуралдааны тоо
1.	Хянан шалгах түр хороо (Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий)	8
2.	Хянан шалгах түр хороо (Хүний эмийн чанарын асуудлаар)	3
3.	Хянан шалгах түр хороо (Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий)	5
<b>Нийт</b>		<b>16</b>

Түүнчлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлт, танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёолол, эцсийн найруулга зэрэг нийт 2673 баримт бичгийг тухай бүр Улсын Их

Хурлын дарга, гишүүд, Тамгын газрын удирдлага болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын холбогдох албан тушаалтнуудад хүргэх ажлыг зохион байгууллаа.

“ “ **Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааны ирцийг бүрдүүлэх, Улсын Их Хурлын гишүүдэд мэдээ, мэдээлэл, холбогдох зар хүргэхэд Мобиком корпорацийн smsnumber.mn үйлчилгээг ашиглан 320 удаагийн давтамжтай 9695 мессеж хүргэв.**

### Хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг олон улсын жишигт нийцсэн загварын дагуу хөтөлж эхэллээ.



Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг шинэчлэх зорилгоор Английн Хансард, Германы Бундестаг, Америкийн Нэгдсэн Улсын Конгресс, Канадын Сенат зэрэг парламентуудын хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг судалж, олон улсын жишигт нийцүүлсэн загварын төслийг боловсрууллаа. Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганаас эхлэн 25 удаагийн чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг дээрх загварт оруулан цахим хуудсанд байршуулан ажилласан.

Цаашид чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс гадна Байнгын, Дэд, Түр хорооны хуралдааны тэмдэглэлийг дээр дурдсан жишигт нийцүүлж, шинэчлэх ажлын хүрээнд дээрх загварын дагуу хөтөлж Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах арга хэмжээг авч ажиллана.



### 1.3. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ 02 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор уг нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталсны дагуу Улсын Их Хурлаар холбогдох хуулийг хэлэлцэн батлах зохион байгуулалтын бэлтгэлхангах, Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төсөл санаачлан боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, судалгаа шинжилгээгээр хангахад анхаарч ажиллав. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Их суудлын хуралдаанаараа Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд 2019 оны 11 дүгээр сарын 14-нд баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан

Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн заалт нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд харшилж, Монгол Улсын Үндсэн хуулийн зохих зүйл, хэсэгт нийцээгүй гэж үзэн хүчингүй болгож, эцэслэн шийдвэрлэсэн.

Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг хэлэлцэх, өөрчлөлтийн уг эхийг нотлон баталгаажуулах, Үндсэн хуульд кодификац хийх, албан ёсны эх болгон хадгалах, хэвлэн нийтлэхэд хуулийн зарим зохицуулалт хийх шаардлага гарсан тул Улсын Их Хурал 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа дээрх асуудлыг хэрхэн хэлэлцэх журам, дэгийг холбогдох хуулиар баталсан.

“**Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 62 гишүүн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлж, холбогдох Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлуулсан болно.**

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд нийт 31

хуульд өөрчлөлт оруулахаар тогтоосон бөгөөд үүнээс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Улсын Их Хурал 18 хуулийг хэлэлцэн баталж, 4 хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд байна.

“**Дээрх 31 хуулиас 4 нь анхдагч, 19 нь шинэчилсэн найруулга, 8 нь нэмэлт, өөрчлөлт байхаар тогтсон бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3 анхдагч, 10 шинэчилсэн найруулга, 5 нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан байна.**

Хууль санаачлагчдаас Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан 126 хуулийн төсөл болон “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон

хамт өргөн мэдүүлсэн 13 хууль, Улсын Их Хурлын 1 тогтоолын төсөл, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 2, холбогдуулан боловсруулсан 2 хуулийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Д/д	Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын жагсаалтаас (Хууль, тогтоолын нэр)	Улсын Их Хурлаас баталсан холбогдох хууль, тогтоолын нэр, огноо
1.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2020.12.24-ний өдөр батлагдсан	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан 126 хуулийн төсөл болон "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол
2.	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2020.05.13-ны өдөр батлагдсан /Нэмэлт, өөрчлөлтийн хэлбэрээр/	Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон хамт өргөн мэдүүлсэн 13 хууль, Улсын Их Хурлын 1 тогтоол
3.	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
4.	Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 2, холбогдуулан боловсруулсан 2 хууль
<b>Нийт</b>	<b>4 хууль</b>	<b>4 багц хууль</b>

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын Их Хурал 2022 оны 52 дугаар тогтоолын 3

дахь заалтаар Улсын Их Хурлын 2022 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар Засгийн газарт чиглэл өгсөн ба тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НИЙЦҮҮЛЭН БАТЛУУЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУДАЛГАА

### 31 БАТЛУУЛАХ ХУУЛЬ



● Анхдагч хууль 4



● Шинэчилсэн найруулга 19



● Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 8

### 18 БАТЛАГДСАН ХУУЛЬ



● Анхдагч хууль 3



● Шинэчилсэн найруулга 10



● Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 5

Дээрх хуулиудаас гадна Улс төрийн намын тухай /Шинэчилсэн найруулга/, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай зэрэг

хуулийн төслийг боловсруулах шатанд мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллалаа.

“ **Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн батлуулах хуваарьт заасан хууль тогтоомжийн 58 хувийг Улсын Их Хурлаас баталсан байна.** ”

## 1.4. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

### ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЭМЖ, ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ

Тамгын газар 2022 онд Улсын Их Хурлаас хууль тогтоох үндсэн чиг үүрэг, бүрэн эрхээ бүтээмжтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд тулгуурласан, Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн нийцлийг хангасан, мэргэшлийн өндөр түвшний зөвлөгөө, туслалцааг шуурхай үзүүлж ажилласан гэж үзэж байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх парламентын шинэчлэлийн зорилтын хүрээнд хууль тогтоомжийн төсөл боловсруулах, төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, хуулийн төсөлд иргэд, олон нийтээс санал авах зэрэг ажлыг тухай бүр нарийвчлан төлөвлөж, зохион байгуулалтыг өндөр түвшинд ханган, ажлын хариуцлага, сахилга, хуулиар тогтоосон дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллав.

Үүний үр дүнд өмнөх онтой харьцуулахад парламентаас баталсан хууль тогтоомж 23 хувь, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 5.3 хувь, Байнгын, дэд, түр хорооны хуралдаан 7.7 хувиар тус тус өссөн нь Улсын Их Хурлаас улсорнынийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэхэд голлох нөлөө үзүүлсэн гэж дүгнэж байна.

Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын биелэлт 58 хувьтай байна. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт тусгагдсан 31 хуулиас 2022 онд 4 хууль, батлагдсан хуультай холбоотойгоор 4 багц хуулийг Улсын Их Хурал хэлэлцэн батлахад зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллав.

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын Их Хурлын 2022 оны 52 дугаар тогтоолын 3 дахь заалтаар Засгийн газарт чиглэл өгсөн бөгөөд Тамгын газар 2023 онд

уг тогтоолын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

Тамгын газраас хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын уялдаа холбоо, бүтээмж, үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох багц журмуудыг шинээр болон шинэчлэн баталж, мөрдөж эхэллээ.

Энэ хүрээнд Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн ёсчлох эхийг бэлтгэх, ёсчлох журам, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга бэлтгэх, хянах журам, “D Parliament” цахим системийг эрхлэн хөтлөх журам, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах үе шатанд холбогдох албан тушаалтны хариуцан гүйцэтгэх ажил, үүргийн хуваарь, жагсаалт, хянан шалгах хуудас зэргийг шинэчлэн батлав.

Түүнчлэн Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхийг дээдэлсэн парламентыг төлөвшүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд Олон Улсын Парламентын Холбоотой хамтын ажиллагааг эхлүүлж, 2022 оны наймдугаар сард харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023 оныг дуустал хэрэгжих хамтын ажиллагаа Улсын Их Хурал, Тамгын газар жендэрийн мэдрэмжтэй байдлын болон хүний эрхийн өөрийн үнэлгээ хийж, цаашдын бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэл, зорилтуудаа тодорхойлох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Тамгын газар 2022 онд хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилсэн нь хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг үр дүнтэйгээр ашиглах боломжийг нэмэгдүүллээ.

Монголын ард түмэн Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан төрийн үйл хэрэгт шууд оролцох, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэх эрх зүйн шинэ орчныг бүрдүүлэх талаар холбогдох судалгаа шинжилгээ, лавлагаа, хуулийн төслийн саналыг боловсруулж, танилцуулсны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орлоо.

Уг өөрчлөлтийн дагуу иргэд тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар асуулт

асуух, санал өгөх эрхээ Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим хуудас, гар утас, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан программ хангамжаар дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд Тамгын газар холбогдох журмыг батлуулах, цахим системийг хөгжүүлэх бэлтгэлийг хангаж ажиллалаа.

Тамгын газар 2023 онд Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр дараах **“зорилт, арга хэмжээ”**-г хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

## **1. Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж, “Шинэ сэргэлт-эрх зүйн шинэчлэл”-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.**

- 1.1. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах, хэлэлцэн батлахад мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө, туслалцаа үзүүлнэ.
- 1.2. Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд холбогдох байгууллагад чиглэл өгсөн Улсын Их Хурлын тогтоолын биелэлтэд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авна.
- 1.3. “Шинэ сэргэлт-эрх зүйн шинэчлэл”-ийн бодлогын хүрээнд холбогдох багц хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг нарийвчлан төлөвлөж, зохион байгуулна.

## **2. Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах тухай 2022 оны 80 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Зөвлөлдөх зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.**

- 2.1. “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах ажлыг хариуцаж, Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах цогц арга хэмжээ авна.
- 2.2. Зөвлөлдөх зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу Улсын Их Хурлаас холбогдох шийдвэр гаргах, хяналт шалгалт явуулахад мэргэжил, арга зүйн туслалцааг шуурхай үзүүлнэ.

**3. Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж, E-Petition цахим систем нэвтрүүлнэ.**

- 3.1. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд оруулсан нэмэлтийг хэрэгжүүлэх зорилгоор цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журмыг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 3.2. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимаар авдаг E-Petition системийг олон улсын жишиг аргачлалын дагуу хөгжүүлж, ашиглаж эхэлнэ.
- 3.3. Хуулийн төсөлтэй холбогдуулан иргэд, олон нийтээс цахим системээр дамжуулан ирүүлсэн саналыг судалж, тухайн төсөлд тусгах боломжтой эсэх талаар санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх, хариу өгөх ажлыг хэвшүүлнэ.

**4. Парламентаас хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй байдлын өөрийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлж, хуулийн төсөлд холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийдэг жишиг тогтооно.**

- 4.1. Улсын Их Хурал, Олон Улсын Парламентын холбоо хооронд байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, парламентаас хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй байдлын өөрийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.2. Хуулийн төсөл хүний эрхийг хангасан, эсэхэд үнэлгээ хийх аргачлалын дагуу хууль тогтоомжийн төсөлд үнэлгээ хийдэг болж, хүний эрхийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх парламентын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.3. Хууль тогтоомжийн төслийг жендэрийн мэдрэмжтэй эсэх шалгуураар үнэлэх үнэлгээний аргачлалыг судалж, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна.





## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



## II БҮЛЭГ

### УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

- 2.1. Хяналт шалгалт, үнэлгээний чиглэлээр
- 2.2. Улсын Их Хурлаас хяналтын сонсгол зохион байгуулахад үзүүлсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, тусалцаа
- 2.3. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ
- 2.4. Төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр
- 2.5. Дүгнэлт, зорилт



## УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

### 2.1. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан бөгөөд 2022 онд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ шинэ хууль, эрх зүйн

орчинд хэрэгжүүлж ажилласан онцлог жил байлаа.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль нь дараах шинэлэг эрх зүйн зохицуулалтыг тусгасан болно. **Үүнд:**

1	УИХ-аас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон төсөвт тавих хяналтын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгасан.
2	УИХ-ын хяналт шалгалтын төрөлжсөн мэдээллийн нэгдсэн сангийн эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.
3	УИХ-ын хяналт шалгалтыг урьдчилан төлөвлөдөг болсон.
4	УИХ-ын хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг хуульчилсан.
5	УИХ-аас хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үр дагаварт үнэлгээ хийх зохицуулалтыг тодорхой болгосон.
6	Асуулга, асуултын хариуг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх зохицуулалттай болсон.
7	Хяналт шалгалтын үйл ажиллагааг төрийн зарим байгууллагыг түшиглэн явуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.
8	Хяналтын сонсголын төрөл, хэлбэр тодорхой болж, нарийвчлан зохицуулсан.
9	Төсвийн хяналтыг байнга тасралтгүй явуулах хэлбэр, нөхцөлийг хангах, төсвийн төслийг нэг удаа Засгийн газарт буцаах эрх зүйн зохицуулалттай болсон.


Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу Байнгын хороод болон намын бүлгээс ирүүлсэн саналыг нэгтгэн Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулган болон 2022 оны

Намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын цаглаврыг 2 удаа боловсруулж, Улсын Их Хурлын даргын захирамжаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.





**Хууль тогтоомжийн биелэлттэй танилцах, хянаж шалгах үйл ажиллагаанд үзүүлсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа:**




2022 онд Улсын Их Хурлын тогтоолоор болон Улсын Их Хурлын даргын захирамж, Байнгын хороо, дэд хорооны тогтоолоор байгуулагдсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тодорхой асуудлыг шалган судлах, хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий нийт 40 Түр хороо, ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 313 гишүүн ажиллахад мэргэжил,

арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд 2020-2021 онд байгуулагдсан 9 ажлын хэсэг үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, 2022 онд 31 Түр хороо, ажлын хэсэг шинээр байгуулагдан ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажлын хэсгийн тоо 7.5 хувиар, ажилласан гишүүдийн тоо 18.2 хувиар өсчээ.

2022 онд Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий 4 Түр хороо, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу хуулийн биелэлтийг

хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг хянан шалгаж, дүнг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах 3 түр хороо байгуулагдан ажиллалаа.



Мөн хууль тогтоомжийн биелэлттэй танилцах, хяналт шалгалт явуулж, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий нийт 33 ажлын хэсэг байгуулагдан

ажилласнаас Улсын Их Хурлын даргын захирамжаар 7 ажлын хэсэг, Байнгын хорооны тогтоолоор 24, дэд хорооны тогтоолоор 2 ажлын хэсэг байгуулагдсан.

**2022 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан 2 түр хороо, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 2, Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 7, дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1, нийт 12 ажлын хэсэг удирдамжид заасан чиг үүргээ хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь дуусгавар боллоо.**

Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн биелэлттэй танилцах, хянан шалгах үйл явцад иргэд, сонгогчид, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажлын хэсгийн хүрээнд 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон, Дархан-Уул, Увс, Завхан, Дундговь зэрэг 15 аймагт нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулан, Улсын Их Хурлын 2 тогтоол, Байнгын хорооны 9 тогтоол, түр хорооны 4 тогтоол, 4 тэмдэглэлээр Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад үүрэг, чиглэл өгч ажилласан болно.

Түүнчлэн хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар 25 байгууллагын үйл ажиллагаатай танилцан, Хэнтий, Төв, Баянхонгор, Архангай,

## I. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

**Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн 3 асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулан ажиллаж байна.**

Хянан шалгах түр хороод нь гадаад улсын парламентын үйл ажиллагаанд жишиг болсон хянан шалгах үйл ажиллагаа явуулж, хуульд заасны дагуу нотлох баримт цуглуулан, тусгай шинжээч, хянан шалгагч томилох, нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол хийж холбогдох гэрч, албан тушаалтнаас мэдүүлэг авах зэргээр асуудлыг тал бүрээс нь шинжлэн судалж, бодит мэдээллийг ард түмэндээ ил болгох замаар Үндсэн хуулийн эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах боломжийг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

*Улсын Их Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо:*

2021 оны сүүлчээр иргэд, олон нийтийн дунд Хөгжлийн банкны зээлүүд хууль бусаар олгогдсон, улс төрд нөлөө бүхий

зарим хүмүүс иргэдийн боломжийг хулгайлсан гэх асуудал хөндөгдсөнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар санаачлан уг асуудлыг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт ажилласан Улсын Их Хурлын гишүүд хууль тогтоомжид заасны дагуу Хянан шалгах түр хороо байгуулж нарийвчлан шалгах шаардлагатай гэсэн саналыг гаргаж, улмаар тогтоолын төслийг өргөн барьсан.

Ийнхүү Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хороо” байгуулагдсан.

Хянан шалгах түр хорооны 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн анхны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарыг даргаар сонгосон. Түр хороо нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд 11 удаа хуралдаж, Хөгжлийн банкны асуудлаарх цаг үеийн нөхцөл байдлын талаар болон хянан шалгагч нарын шалгалтын ажлын явцын талаар 5 удаагийн мэдээлэл сонсож, түр хорооны үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой 12 тогтоол баталсан байна.



Түр хорооны хуралдаан

Түүнчлэн хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, баримт бичиг ирүүлэхийг хүссэн албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, ирүүлсэн материалтай танилцан нотлох баримт цуглуулах, нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж тэмдэглэл үйлдэх, цуглуулсан нотлох баримт болон холбогдох бусад бичиг

баримтуудыг шинжлэн судалж, дүн шинжилгээ хийх зэргээр ажилласан.

Хянан шалгах түр хороо нь шалгалтын явцад тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргуулах зорилгоор Монголбанк, Үндэсний аудитын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг холбогдох төрийн байгууллагаас хянан шалгагч, шинжээч нарыг томилсон болно.

“ “ **Хянан шалгах түр хорооны дарга Ж.Сүхбаатар Засгийн газрын гишүүнээр томилогдсон тул түр хорооны 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар даргаас чөлөөлж, Түр хорооны 06 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярыг даргаар сонгосон.**

Хянан шалгах түр хорооны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо”-ноос нотлох баримтыг шинжлэн судлах сонголыг 3 үе шаттайгаар зохион байгуулах тухай тогтоол баталсны дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү сонсгол нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу зохион байгуулагдаж буй анхны нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол юм.

*Улсын Их Хурлын 2022 оны 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо:*



Манай улсын дотоодын зах зээлд байгаа эм нь өндөр хөгжилтэй орны зах зээлд байгаа эмтэй орц, найрлагын хувьд ижил боловч үйлчлэлийн хувьд харилцан адилгүй нөлөөтэй байгаа нь эмийн чанар, аюулгүй байдалд тавих хяналт шалгалтын үр нөлөө бага, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг мөрдөхгүй байгаатай холбоотой гэж үзэн Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 21 гишүүн уг асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах тогтоолын төслийг өргөн барьсны дагуу Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор “Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо” байгуулан ажилласан.

Хянан шалгах түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал ажилласан бөгөөд дотоодын болон импортын эмийн чанар, стандартын өнөөгийн байдал, эмийн хяналтын тогтолцооны талаар холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг сонсож, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн шинжилгээний лаборатори болон “Монос” эмийн үйлдвэрийн Эм бэлдмэл, сорилтын лабораторийн нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан.

Улсын Их Хурлын 2022 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч

байгаа хүндрэлийг шалган тогтоож Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо:



Түр хорооны хуралдаан

Монгол Улсын 2022 оны төсөвт төлөвлөж байсан нүүрсний экспортын биет тоо хэмжээ саарч, төлөвлөгөө тасрах, улмаар нүүрсний экспортоос улсын төсөвт төвлөрүүлэх орлого тасалдах нөхцөл байдал үүссэн, мөн Монгол Улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн зардал болон хүнс, өргөн хэрэглээний барааны үнэ өссөн шалтгаан, нөхцөлийг нарийвчлан шалгах шаардлага үүссэний улмаас Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа нарын гишүүд Хянан шалгах түр хороо байгуулж нарийвчлан шалгах шаардлагатай талаар санал гаргаж, улмаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах тогтоолын төслийг өргөн барьсан юм.

Ийнхүү Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор “Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох” үүрэг бүхий хянан шалгах түр хороог олонх болон

цөөнхийн төлөөллийг оролцуулан 13 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Түр хорооны 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн анхны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдыг хянан шалгах түр хорооны даргаар сонгосон. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын 10-нд Улсын Их Хурлаас тус хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг зургаан сар хүртэлх хугацаагаар сунгаж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд Түр хороо 6 удаа хуралдаж, ажлын даалгаврыг батлах, хянан шалгагч, шинжээч нарыг томилон, холбогдох төрийн байгууллагуудын нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой мэдээлэл сонсож, түр хорооны үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой 10 тогтоол баталсан байна.

**“Хянан шалгах түр хороо нь тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргуулах зорилгоор хянан шалгах түр хороонд хараат бус 5 хянан шалгагч, 3 шинжээч томилон ажиллаж байна.**

Түр хороо 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох хүрээнд холбогдох төрийн байгууллагуудын чиг үүрэг,

хэрэгжилт, хяналт шалгалтын талаарх ерөнхий мэдээллийг сонсох ажлыг зохион байгуулсан. Энэ үер Гаалийн ерөнхий газраас 2013, 2018 болон 2022 онд нүүрсний экспортын үйл ажиллагаатай холбогдуулан хийсэн шалгалтын ажлын мэдээллийг танилцуулсан.

## II. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН ТҮР ХОРОО

*Улсын Их Хурлын 2020 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хороо:*



2022 онд Түр хороо нийт 5 удаа хуралдаж, 2021 онд Монгол Улсын Засгийн газраас болон Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, вакцинжуулалт, “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын нөхцөл байдал, шинэ төрөл, чиг хандлага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, зөвлөмж”, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, цар тахлын нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагын танилцуулга, мэдээллийг сонсож, Түр хорооны хуралдаанаас 3 удаа Засгийн газар болон бусад байгууллагад үүрэг,

чиглэл өгсөн байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Түр хороо ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулснаар түүнийг татан буугдсанд тооцно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Түр хороо ажлын үр дүнгээ танилцуулснаар татан буугдсан болно.

*Улсын Их Хурлын 2022 оны 48 дугаар тогтоолоор байгуулагдсан Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороо:*

Түр хорооны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг Түр хорооны даргаар томилсон бөгөөд Хууль, эрх зүйн орчныг сайжруулах болон санхүү төсвийн асуудлыг судалж, санал боловсруулах, Мал аж ахуйн үйлдвэрлэлийн асуудлаар судалж, санал боловсруулах, Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр судалж, санал боловсруулах, Мал эмнэлгийн чиглэлээр судалж, санал боловсруулах үүрэг бүхий 4 чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажилласан байна.

Түр хороо 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн тогтоолоороо Засгийн газарт чиглэл өгч, 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд тайлан, санал, дүгнэлтээ танилцуулснаар татан буугдсан.



*Түр хорооны хуралдаан*

### III. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ



**2022 онд Улсын Их Хурлын даргын захирамжаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий 7 ажлын хэсэг ажилласнаас дараах 2 ажлын хэсэг удирдамжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж, үйл ажиллагаа нь дуусгавар болсон бөгөөд 5 ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.**

Шийдвэр	Ажлын хэсгийн үйл ажиллагаа
<p>Улсын Их Хурлын даргын захирамж 2022.01.31, №20</p> <p>Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсэг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу Хөгжлийн банкны нөхцөл байдалтай танилцаж, банкны удирдлагуудтай уулзаж, удирдамжийн хүрээнд шаардлагатай тодруулга, мэдээлэл авах, шалгалтын чиглэлээр ажлын дэд хэсэг байгуулан ажиллуулах, уулзалт, ярилцлага зохион байгуулах зэргээр ажилласан.</p> <p>2022.03.28-ны өдөр ажлын хэсэг Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын үнэлгээчидтэй хамтран ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн нийт ажлын талаар нэгтгэн хэлэлцэв.</p> <p>2022.03.29-ний өдөр зохион байгуулсан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголд тайлангаа танилцуулснаар ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.</p>
<p>Улсын Их Хурлын даргын захирамж 2022.12.05, №190</p> <p>Нүүрсний олборлолт, тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлыг шалгаж, олон нийтэд нээлттэй, ил тод болгох, хууль хяналтын байгууллагуудын шалгалтын ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор ард иргэдийн оролцоог хангаж ерөнхий хяналтын сонсголыг нэн даруй зохион байгуулж, үр дүнг тайлагнах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсэг нийт 3 удаа хуралдаж, ерөнхий хяналтын сонсгол хийх асуудлууд, ерөнхий хяналтын сонсголын нарийвчилсан төлөвлөгөө болон нүүрсний олборлолт, тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаар ерөнхий хяналтын сонсголыг 2022.12.21-ний өдөр зохион байгуулахтай холбоотой асуудлыг хэлэлцсэн.</p> <p>Ажлын хэсэг ЭЗБХ-ны 2022.12.28-ны өдрийн хуралдаанд 2022.12.21-ний өдөр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулсан талаарх тайлангаа танилцуулсан.</p> <p>2023.01.06-ны өдрийн чуулганы хуралдаанд ажлын хэсгийн тайланг танилцуулснаар үйл ажиллагаа дуусгавар болсон.</p> <p>2023.01.19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар "Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоол баталсан.</p>

### IV. БАЙНГЫН, ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Байнгын, дэд хорооноос өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд тодорхой асуудлаар шалган судлах, эсхүл хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий 26 ажлын хэсэг байгуулан ажилласан байна.

Эдгээр ажлын хэсгийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн

байдал, тулгамдаж буй асуудлын талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцах, нөхцөл байдлыг газар дээр нь очиж судлахаар хөдөө, орон нутагт ажиллах зэргээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, 2022 онд 8 ажлын хэсэг удирдамжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж, үйл ажиллагаагаа дуусгавар болгосон.

## 2.2. УЛСЫН ИХ ХУРЛААС ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

2022 онд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу нийт 9 удаагийн хяналтын

сонсгол зохион байгуулснаас ерөнхий хяналтын сонсголыг 2 удаа, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг 1 удаа, нэр дэвшигчийн сонсголыг 6 удаа тус тус зохион байгуулсан байна.



Ерөнхий хяналтын сонсгол

“**Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ:**



Хурлын гишүүн Б.Баттөмөрөөр ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж, С.Чинзориг нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны ээлжит бус чуулганы 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ч.Хүрэлбаатар, Д.Ганбат, Б.Баттөмөр, Б.Пүрэвдорж, Б.Энх-Амгалан нарын гишүүд Хөгжлийн банкны асуудалд Улсын Их Хурлаас анхаарах, шаардлагатай бол хяналт шалгалт хийх асуудлыг хөндсөн бөгөөд гишүүдийн саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дэмжиж, 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжаар “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг Улсын Их

Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, 01 дүгээр тогтоолоороо “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах Ерөнхий хяналтын сонсгол”-ыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг томилсон юм.

2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсан бөгөөд нийт 170 гаруй оролцогч оролцсон болно. Сонсголын тайлан, мэдээлэл сонсох хэсэгт Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд холбогдох төрийн байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтын талаар танилцууллаа.





Ерөнхий хяналтын сонсгол

“ **Чанар, стандартын шаардлага хангахгүй барилгын материалын химийн нэгдлээс хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөлөөллийн талаар болон барилгын дотор орчны агаарын чанарын асуудлаар ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ:**



Чанар стандартын шаардлага хангаагүй барилгын материалаас ялгарч буй химийн нэгдэл нь хүний биед сөрөг нөлөө үзүүлдэг төдийгүй амьсгалын замын болон зүрх, судасны

өвчнөөр өвчлөх, хавдар үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж, бага насны хүүхдийн эрүүл мэнд гадаад болон дотоод орчны агаарын чанарт шууд нөлөөлж байдаг.

Монгол Улсын иргэд, хүүхэд багачуудын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурах, ажиллах эрхийг хангах зорилгоор Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын есөн гишүүн Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, үр нөлөөг сайжруулах, тухайн чиг үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэдээлэл авах, үнэлэх зорилго бүхий хяналтын сонсгол явуулах хүсэлт гаргасан бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хяналтын сонсголыг зохион байгууллаа.

“ **Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ:**

Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 190 дүгээр захирамжаар “Нүүрсний олборлолт, тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлыг шалгаж, олон нийтэд нээлттэй, ил тод болгох, хууль хяналтын байгууллагуудын шалгалтын ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор ард иргэдийн оролцоог хангаж Ерөнхий хяналтын сонсголыг нэн даруй зохион байгуулан үр дүнг тайлагнах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 18 дугаар тогтоолоор “Нүүрсний экспорт, тээвэрлэлтэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах” ерөнхий хяналтын сонсголыг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг томилогдон ажилласан.




Ерөнхий хяналтын сонсголыг 2020-2022 онуудад олборлосон нүүрс, тээвэрлэсэн аж ахуйн нэгж, экспортолсон боомт, олсон орлого, коксжих нүүрсний дэлхийн болон БНХАУ-ын зах зээл дээрх үнэ, хилийн болон уурхайн аман дээр борлуулж буй үнийн зөрүү, түүний шалтгаан, үнийн зөрүү нь хоёр улсын тодорхой этгээдүүдийн авлига, хууль бус үйл ажиллагааны орлого, татвараас зайлсхийхэд нөлөөлсөн эсэх, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд өнөөг хүртэл төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /Оффтейк/ болон төлбөрийг урьдчилан

авч ашигласан гэрээнүүдийн талаар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдэд ямар хэлбэрээр, хэдий хэмжээний санхүүжилт гарган оролцсон, эдгээр төмөр замуудын 1 км тутмыг ямар өртгөөр барьж байгуулсан тухай, нүүрсний асуудлаар 2013 оноос хойш шийдвэрлэгдсэн, хэрэгсэхгүй болсон хэргүүдийн талаарх мэдээлэл, шалгагдаж байгаа хэргүүдийн явц, шийдвэрлэлтийн байдлын талаарх сэдвүүдийн хүрээнд зохион байгууллаа.

**Улсын Их Хурлын гишүүнээс асуулга, асуулт тавихад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн талаар:**

**АСУУЛГА:** Улсын Их Хурлын 46 гишүүнээс (давхардсан тоогоор) Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад хандан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж,

ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, хуульд заасан үйл ажиллагаа явуулахыг шаардаж 35 асуулгыг 203 асуудлаар тавихад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, асуулгын хариуг хуульд заасан хугацаанд хүлээн авч асуулга тавьсан гишүүнд хүргүүлсэн.






Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийв.

“ Асуулга тавьсан гишүүдээс 15 асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг ирүүлж, тайлант хугацаанд 9 асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсох ажлыг зохион байгуулж, хэлэлцүүлсэн.

**АСУУЛТ:** Улсын Их Хурлын 16 гишүүнээс (давхардсан тоогоор) Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд тодорхой бодлогын асуудал, түүний санхүүжилт, төрийн санхүү, төрийн нийтийн өмч, хүний эрх, эрх чөлөө хангагдаж байгаа эсэх асуудал болон Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг

нь сонгож, томилдог байгууллагын хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж байгаатай холбоотой мэдээлэл авахаар тухайн байгууллагын даргад хандан 16 асуултыг 45 асуудлаар тавихад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, тэдгээрийн хариуг хуульд заасан хугацаанд ирүүлэхэд хяналт тавьж ажилласан байна.



Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээс ХХААХҮ-ийн сайдад хандаж “Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”

тавьсан асуултын хариуг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, “Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг батлуулсан.

**Улсын Их Хурлаас мэдээлэл сонсох, тайлан мэдээлэл хэлэлцэхэд үзүүлсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа:**

“ 2022 онд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын хийсэн дараах 11 мэдээллийг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан.




Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, хуулийн хэрэгжилтийн талаарх өргөдөл, гомдол хүлээн авах "D.Parliament" цахим системээр дамжуулан иргэд Ерөнхий сайдын хийх мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс асуулт асуух, хариулт авах боломжийг бүрдүүлсэн.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын 2022 оны намрын чуулганы хугацаанд Ерөнхий сайдын хийсэн 6 удаагийн мэдээллийг D.Parliament цахим системд байршуулан, 27 иргэнээс ирүүлсэн 36 асуултыг намын бүлгүүдэд ангилан багцалж хүргүүлсэн бөгөөд чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс эдгээр асуултыг асууж, хариулт авсан болно.

### Байнгын, дэд, Түр хорооны хуралдаанаар тайлан, мэдээлэл сонсоход туслалцаа үзүүлсэн талаар:

2022 оны жилийн эцсийн байдлаар Байнгын, дэд болон түр хорооны хуралдаанаар нийт 38 удаагийн тайлан, мэдээлэл сонсоход давхардсан тоогоор Улсын Их Хурлын нийт 348 гишүүн 967

асуулт асууж, санал хэлсэн статистик мэдээллийг Хяналт шалгалт, үнэлгээний газрын мэдээллийн санд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.



Мэдээлэлтэй холбогдуулан Засгийн газар, холбогдох бусад байгууллагад үүрэг, чиглэл өгсөн нийт 10 шийдвэрийн төслийг

боловсруулж, батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

### 2.3. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсанаар Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр нөлөөг үнэлэх байнгын тогтолцоог бүрдүүлэх, чадавхжуулах эрх зүйн орчин бүрдсэн. Тухайлбал, Улсын Их Хурлын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын цаглаврын дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийж байна. Мөн Улсын Их Хурлын даргын 2022 оны 77 дугаар захирамжаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх журам”-ыг баталснаар Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн

хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Түүнчлэн Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт болон уялдаа холбоо, нийцэлд Тамгын газар дүн шинжилгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн. Энэ хүрээнд тайлант хугацаанд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” хоорондын уялдаа холбоо болон 2021 оны хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийлээ.

“**Тайлант хугацаанд Улсын Их Хурлын даргын захирамжаар батлагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын цаглаврын дагуу дараах 8 хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийлээ.**

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний талаарх мэдээлэл:

<b>БОХХААБХ</b>	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд хяналт шинжилгээ	<b>УИХ дахь Монгол Ардын Намын бүлэг</b>	УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт шинжилгээ
<b>УИХ дахь Монгол Ардын Намын бүлэг</b>	УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт шинжилгээ	<b>БСШУСБХ</b>	Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ
<b>БОХХААБХ</b>	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ	<b>НБХ</b>	Гэр бүлийн хучирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн /20 дугаар зүйл/ хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ
<b>ТБХ</b>	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ	<b>УИХ дахь Ардчилсан Намын бүлэг</b>	Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ

## Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын тайлан, илтгэлд хийсэн шинжилгээ

### ХЗБХ

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлд хийсэн шинжилгээ

### ЭЗБХ

СЗХ-ны 2021 оны үйл ажиллагааны тайлан болон урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тус байгууллагын чиг үүрэгт хамаралтай тусгагдсан зорилго, зорилтын 2021 оны хэрэгжилтэд хийсэн шинжилгээ

### ЭЗБХ

Статистикийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх ҮСХ-ны тайланд хийсэн шинжилгээ

### НББХ

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ

### ТБХ

Үндэсний Аудитын байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ

### ТБХ

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланд хийсэн шинжилгээ

### НББХ

ЭМ-ийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ

### ТББХ

Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх ТАЗ-ийн тайланд хийсэн шинжилгээ

### НББХ

Шүүхийн сахилгын хорооны 2021 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулиар тусгайлан заасан нийт 9 тайланд

шинжилгээ хийж, Байнгын хороод болон Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж ажиллалаа.



**“Монгол Улсын Засгийн газрын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2021 оны хэрэгжилтийн дүн шинжилгээний тайлан, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн биелэлтийг Байнгын хороодоор хэлэлцүүлэх хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газраас хэрэгжилтийн хувь бууруулж үнэлсэн 105 арга хэмжээний шалтгаан нөхцөлийн талаар мэдээлэл бэлтгэн, Байнгын хороод болон Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж ажиллалаа.**

Түүнчлэн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо болон хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”

болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” хоорондын уялдаа, дэвшүүлсэн зорилтот түвшингийн 2021 оны хэрэгжилтийн талаар танилцуулга бэлтгэн, холбогдох Байнгын хороодод хүргүүлсэн болно.

### Улсын Их Хурлаас Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хяналт

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, холбогдох

албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийн холбогдох Байнгын хороонд хүргүүлэхээр заасан.

Энэ хүрээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад үүрэг, чиглэл болгосон 154 хуулийн 632 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 107 тогтоолын 540 заалт, Байнгын

болон дэд, түр хорооны 109 тогтоолын 677 заалтыг Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн санд бүртгэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

### Улсын Их Хурлаас хяналтад авсан хууль тогтоомжийн хэсэг, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Он	Монгол Улсын хууль		Улсын Их Хурлын тогтоол		Байнгын хорооны тогтоол	
	Хяналтад байгаа хууль	Хэсэг, заалт	Хяналтад байгаа УИХ тогтоол	Заалт	Хяналтад байгаа БХ-ны тогтоол	Заалт
2019	101	515	81	268	98	668
2020	103	391	84	314	76	408
2021	126	516	94	296	96	535
2022	154	632	107	540	109	677

## 2.4. ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА:

“ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлаас Улсын төсөвт хийх хяналт шалгалтыг 2022 онд төсвийн төлөвлөлтийн, төсвийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үе шатны, төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатны, төсвийн гүйцэтгэлд хийх хяналтын хэлбэрээр хэрэгжүүлээ.

### Төсвийн төлөвлөлтийн хяналт



Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага хангасан эсэхэд дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

### Төсвийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үе шатны хяналт

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар Улсын төсвийн хяналтыг үе шат бүрд хийх боломжийг бий болгосон. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д зааснаар нийт 38 төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 оны төсвийн саналаа 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн төслийн саналыг урьдчилан авснаар батлагдсан төсвийн хязгаартаа багтсан эсэхийг шинжлэх, 2021, 2022 оны батлагдсан төсөвтэй харьцуулан зардлын зүйл бүрээр дүн шинжилгээ хийж, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төлөвлөлтийн байдал, бодлогын уялдааг тодорхойлоход ашиглах боломж бүрдсэн.

## Төсвийн хэлэлцүүлгийн үе шатны хяналт

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 28, 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлснээр Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүн шинжилгээ хийсэн.

Төсвийн байнгын хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамтран 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр "Төсвийн бодлогын шинэчлэл" сэдэвт хэлэлцүүлэг, 2022 оны 10 дугаар 19-ний өдөр "Төсөв-2023" олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

"Төсөв-2023" хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хүрээнд "D-Parliament" цахим системийг ашиглан иргэд, олон нийтэд Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг танилцуулж, саналыг төсөлд тусгасан нь төсвийн төслийг олон нийтээр хэлэлцүүлж, санал авсан анхны тохиолдол боллоо. 2022 оны 10 дугаар сарын 07-ноос 17-ны өдрүүдэд 10 хоногийн хугацаанд иргэдээс

санал авахад 15,293 иргэн Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлтэй танилцаж төсвийн талаарх бодит мэдээллийг эх сурвалжаас нь авсан байна. Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд иргэдээс d@parliament.mn майлээр 329 санал, утсаар 167 санал, "D-Parliament" цахим системээр 302 санал, нийт 798 санал ирүүлсэн.

Үүнээс гадна "D-Parliament" цахим системээр дамжуулан 170 сэтгэгдэл үлдээсэн байна. Иргэдээс ирүүлсэн саналуудыг салбараар нь ангилан үзвэл боловсрол, шинжлэх ухааны салбарын асуудлаар 46.1 хувь буюу 368 санал, эдийн засаг, санхүүгийн салбартай холбоотой асуудлаар 23.8 хувь буюу 190 санал, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын асуудлаар 7.4 хувь буюу 59 санал, барилга, хот байгуулалтын салбарын асуудлаар 5.1 хувь буюу 41 санал өгсөн байна. Эдгээр саналуудыг төсвийн төслийг хэлэлцэх үед харгалзан үзсэн болно. Төсвийн тухай хуулийн төсөлд тусгасан 38 төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд шинжилгээ хийж, томоохон өөрчлөлт орсон зардлуудын танилцуулгыг бэлтгэж, тайлбар мэдээллээр баяжуулан, харьяалах 11 Байнгын хороонд хүргүүлсэн.



## Төсвийн гүйцэтгэлийн хяналт

Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлд бодлогын болон холбогдох хуульд нийцсэн эсэхтэй холбоотой дүн шинжилгээ хийж, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн тайланг боловсруулж, Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Монгол Улсын 2021


оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хэлэлцүүлэгт зориулж 35 ерөнхийлөн захирагчийн зарлагын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн Байнгын хороодыг мэдээллээр хангасан болно.





**Төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр судалгаа, санал дүгнэлт, танилцуулга 13 удаа хийсэн нь өнгөрсөн оноос 15 хувиар өссөн үзүүлэлт юм.**

### СУДАЛГАА, САНАЛ ДҮГНЭЛТ, ТАНИЛЦУУЛГА



● 2017 он ● 2018 он ● 2019 он ● 2020 он ● 2021 он ● 2022 он

#### Макро эдийн засаг, төсвийн талаар мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байдал

Улсын нэгдсэн төсөв, мөнгөний нийлүүлэлт, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, албан нөөц, ажил эрхлэлт, бодит салбартай холбоотой цогц мэдээллийг багтаасан Монгол Улсын макро эдийн

засгийн 2021 оны урьдчилсан гүйцэтгэл, 2022 оны эхний 3 улирлын макро тойм танилцуулга гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж ажиллав.



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН УЛИРЛЫН ТАНИЛЦУУЛГА



ГАДААД ХУДАЛДААНЫ САР БҮРИЙН ТАНИЛЦУУЛГА



ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН САРЫН МЭДЭЭ

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ болон татварын орлого бүрдэлтийн 2021 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэл, 2022 оны 1-11 сарын гүйцэтгэлийн

танилцуулгыг бэлтгэн боловсруулж, нийт 12 удаа Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагуудыг мэдээллээр хангаж ажилласан.



**Түүнчлэн Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 347 дугаар захирамжаар “Төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлал”-ыг баталлаа.**

#### Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаанд үзүүлсэн мэргэжил, арга зүй, техникийн туслалцаа

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг зохион байгуулах, бусад байгууллагуудтай хамтран ажиллахад мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллалаа. Тухайлбал “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлгийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс санаачлан Төсвийн байнгын хороо, Сангийн яамтай

хамтран зохион байгуулсан байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн 6.4 дэх хэсэгт “Зөвлөлийн үйл ажиллагаанд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дэргэдэх Төсвийн шинжилгээний алба дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс холбогдох мэдээлэл, судалгааг бэлтгэсэн.

## 2.4. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

### УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЭМЖ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр Монгол Улсад парламентын хяналт шалгалтын шинэ тогтолцоо бүрдэх үндэс суурийг тавилаа.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын Их Хурлын даргын 2022 оны 77 дугаар захирамжаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх журам”-ыг баталснаар Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх байнгын тогтолцоо, ажиллах механизм бүрдэв.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 144 дүгээр захирамжаар Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн чиг үүргийг шинэчлэн баталж, шинэ чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, холбогдох нэгжийн орон тоо, албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж, мөрдүүлэх зэрэг бодлогын цогц арга хэмжээ авсан нь Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх чиглэлээр ажлын уялдаа холбоог сайжруулах, бүтээмж, үр дүнг дээшлүүлэхэд өөрэг нөлөө үзүүлж байна.

Тамгын газар 2022 онд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу 9 удаагийн хяналтын сонсгол зохион байгуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажилласан.

Түүнчлэн Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хяналт

шалгалт явуулж, дүнг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах 3 түр хороо байгуулагдан ажилласан нь парламентын хяналт шалгалтад хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага, хөндлөнгийн шинжээч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт шалгалт нь бодитой мэдээлэлд тулгуурласан, үр нөлөөтэй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хянан шалгах түр хороодоос гадна Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хорооноос 37 ажлын хэсэг байгуулагдсан нь өмнөх онтой харьцуулахад 7.5 хувь, ажилласан гишүүд давхардсан тоогоор 313 буюу 18.2 хувиар нэмэгдсэн нь парламентын хяналт шалгалтын хүрээ өргөжиж, шинэ хуулийн хүрээнд гарсан бодлогын өөрчлөлтийн үр дүн гэж дүгнэх үндэслэлтэй юм.

Тамгын газар ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлаас хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврыг хоёр удаа боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Мөн парламентаас төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг боловсронгуй болгох хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр “Төсөв-2023” олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг анх удаа зохион байгуулж, D-Parliament цахим систем, утас, цахим шуудан болон бусад хэлбэрээр 798 санал ирүүлснийг төсвийн төсөлд тусган батлуулсан нь улсын төсөв хэлэлцэн батлах үйл ажиллагаанд шинэ жишиг тогтоов.

Тамгын газар 2023 онд Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр дараах **“зорилт, арга хэмжээ”**-г хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

**1. Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн, хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй зохион байгуулж, хяналт шалгалтын төрөлжсөн мэдээллийн нэгдсэн санг хэрэглээнд нэвтрүүлж, ажиллах журмыг тогтооно.**

- 1.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр нөлөөг дүгнэх, хяналт шинжилгээ хийхэд шаардлагатай төрөлжсөн мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлтийг дуусгаж, хэрэглээнд нэвтрүүлэн, ажиллах журмыг батална.
- 1.2. Улсын Их Хурлаас хяналтын сонсгол явуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх, нийтийн сонсголын талаарх иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.3. Хяналт шалгалтын ажлын хэсгийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийхэд шаардлагатай гарын авлагаар ханган, баримт бичгийн нэгдсэн загвар гаргаж, ашигладаг болно.

**2. Улсын Их Хурлын гишүүний асуулга, асуултын хариуг чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.**

- 2.1. Улсын Их Хурлын гишүүний асуулга, асуултын хариуг хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг хуулийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.
- 2.2. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайдын болон Засгийн газрын гишүүний хийх мэдээллийг зохион байгуулах механизмыг оновчтой болгох хүрээнд иргэдийн оролцоог хангах мэдээллийн технологид суурилсан шинэ арга зүй нэвтрүүлж, хэрэгжүүлнэ.

**3. Төсвийн ил тод байдлыг хангахад дэмжлэг үзүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийж, төсөвт үзүүлэх зардлын нөлөөллийн тооцоо хийх механизм бүрдүүлнэ.**

- 3.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөө, төсөвт үзүүлэх зардлын нөлөөллийн тооцоо хийх аргачлалыг шинээр баталж, мөрдүүлнэ.
- 3.2. Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд макро эдийн засаг, төсөв, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэлд тогтмол дүн шинжилгээ хийж, төсвийн хэлэлцүүлэг явуулахад шаардлагатай мэдээллээр шуурхай хангаж ажиллана.

The logo icon consists of a white square with rounded corners. Inside the square, there is a white mouse cursor arrow pointing towards the bottom-left corner. Above the arrow, there are several short, orange lines radiating outwards, resembling a sunburst or a signal. 

# Parliament

Таны Төлөө

Тантай Хамт

Цахим Парламент



## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



### III БҮЛЭГ

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМ ШИЛЖИЛТЭД ШИЛЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

- 3.1. Улсын Их Хурлын үйл ажиллагааны цахим шилжилт
- 3.2. Тамгын газрын үйл ажиллагааны цахим шилжилт
- 3.3. Хуралдааны цахим системийн үйлчилгээ
- 3.4. Дүгнэлт, зорилт

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМ ШИЛЖИЛТЭД ШИЛЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

## 3.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТ

Улсын Их Хурлын үйл ажиллагаанд D-Parliament вэб болон аппликэйшн хосолсон цахим системийг 2022 оны дөрөвдүгээр сараас эхлэн нэвтрүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон боловсруулалтын шатанд байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд иргэдийн саналыг авах, цахим санал асуулга явуулах боломжтой болсон нь хууль тогтоох ажиллагаанд иргэдийн бодитой оролцоог хангасан, ил тод, эргэх холбоотой цахим парламентыг төлөвшүүлэх үйл хэрэгт томоохон дэвшил гарлаа.

Улсын Их Хурлын цахим шилжилтэд гарч буй ийм өөрчлөлт, шинэчлэлтийг үр дүнд хүргэх, цахим парламентын бодлого, зохицуулалтыг тодорхойлж, олон улсын парламентын жишигт нийцсэн шинэ технологи, инновац нэвтрүүлэх, Улсын Их Хурал, Тамгын газрын хэмжээнд мэдээллийн менежментийн үр нөлөө бүхий тогтолцоо бүрдүүлэх зорилготой Тамгын газрын бүтцийн нэгж болох Цахим парламент, инновацийн газар байгуулагдаж, мэдээллийн технологийн бодлого, үйл ажиллагааны хүрээ өргөжив.

### Парламентын цахим шилжилтийн хүрээнд хийгдсэн D-Parliament системийн ашиглалт

# Parliament

Улсын Их Хурлын 2019-2024 оны Стратеги төлөвлөгөө, Улсын Их Хурлын Тамгын газрын 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөнд Улсын Их Хурлын үйл ажиллагааг цахимжуулах зорилтыг дэвшүүлсэн.

Хууль тогтоох үйл хэрэгт иргэд, олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн вэб, аппликэйшн хосолсон "D-Parliament" цахим системийг 2022 онд хэрэглээнд нэвтрүүллээ. Энэхүү цахим систем нь Улсын Их Хуралд өргөн барьсан хуулийн төсөлд иргэд, сонгогчдын санал авах, цахим хэлэлцүүлэг өрнүүлэх, иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах, Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан иргэд асуулт асуух, Улсын Их Хурлын гишүүдэд өргөдөл, гомдол, санал хүсэлтээ шууд илгээх албан ёсны цахим талбар болж ашиглагдаж байна.



5250



"D-Parliament" системд  
бүртгүүлсэн хэрэглэгчийн тоо

206,654

d.parliament.mn цахим  
хуудасны нийт хандалтын тоо

2526



ДАН системийн баталгаажуулалт хийсэн  
хэрэглэгчийн тоо

48,128



d.parliament.mn цахим хуудсанд хандсан  
хэрэглэгчид (давхардсан тоогоор)

Хамгийн их үзэж танилцсан төсөл:

1. Гэрийн тэжээвэр амьтны тухай

11,144

2. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай

6281

3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл

4255

Системд  
байршуулсан  
төслийн тоо

Боловсруулагдаж байгаа төсөл

69 нийт

40 идэвхтэй

Өргөн мэдүүлэгдсэн төсөл

193 нийт

120 идэвхтэй

Тус цахим системд хууль, тогтоолын төслүүдийг байршуулж, иргэдийн саналыг авах үйл ажиллагаа тогтмолжиж, хэрэглэгчдийн хандалт байнга нэмэгдэж байна. Тухайлбал, "Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль"-ийн төслийг 11,144 хүн үзэж танилцаж, 200 гаруй санал бүртгэгдсэн байна.



## Хуралдааны цахим системийн шинэчлэлт /I шат/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны цахим системийн иж бүрэн шинэчлэлтийг 2022-2023 онд хийхээр төлөвлөн I шат буюу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимын цахим системийн шинэчлэлтийг эхлүүлээд байна.

Шинэ системийг хэрэглээнд нэвтрүүлснээр хуралдааны системийн технологи аналогоос дижиталд шилжиж, хуралдааныг онлайнаар, танхимаар, хосолсон хэлбэрээр зохион байгуулах, оролцогчид нэг ижил программ хангамж ашиглах, нийтийн хэрэглээний Zoom программыг хэрэглээнээс гаргаж,

мэдээллийн аюулгүй байдал хангагдах, санал хураалтын ажиллагаа найдвартай, хялбар болох, цахим карт, хурууны хээ таних технологи сайжрах, техник тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх, хуралдааны удирдлагын системийн нэгдсэн динамик шийдэлтэй болох, хуралдааны системийн дуу дүрсний чанар сайжрах, суурилагдах тоног төхөөрөмжүүдэд шуурхай засвар үйлчилгээ хийх техникийн боломж нөхцөл бүрдэж, хуралдааны үеийн техникийн хүлээлт, тасалдлыг арилгах давуу тал бий болно.

## 3.2. ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТ

### Албан ёсны цахим хуудасны шинэчлэлт

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас болох [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудсыг иж бүрэн шинэчлэв. Энэ хүрээнд үндсэн цахим хуудаснаас гадна дэд цахим хуудсуудасны дизайн, программчлалын технологийн хувьд бүрэн шинэчлэгдсэн. Монгол, англи хэлний хувилбараас гадна монгол бичгийн хувилбарыг нэвтрүүлэх, Улсын

Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны онлайн шууд дамжуулалтын чанар дээшлэх, мобайл хувилбартай болсноор бүх төхөөрөмж дээр загвар дизайны хувьд эвдрэлгүй ажиллах, хайлтын систем сайжрах, хуулийн сангийн өргөтгөсөн хайлтаар нэвтрэх зэрэг олон давуу тал бий болсон.

### Хуралдааны цахим системийн ашиглалт, бүртгэлийн программ

Хуралдааны нэр, цагийн хуваарь, хуралдааны системийг хариуцан ажиллах ажилтан, хуралдааны танхимын мэдээллийг нэгтгэн оруулж цахим бүртгэл хөтлөн тоон мэдээлэл, тайланг нарийвчлан гаргах боломжтой хуралдааны цахим систем ашиглалт, бүртгэлийн программ хангамжийг Хуралдааны систем хариуцсан алба өөрсдийн нөөцөөр хөгжүүлэн, өдөр

тутмын үйл ажиллагаандаа шинээр нэвтрүүлж ашиглаж эхэлсэн.

Ингэснээр хуралдааны цахим системийн оператороор ажиллах ажилтнуудын ажлын ачаалал тэнцвэржиж, хуралдааны бодит тоон мэдээллийг шуурхай гаргах боломжтой болсон.

### Хуралдааны цахим системийн ашиглалтын тоон мэдээлэл /2020-2022 он/

ХУРАЛДААН	2020 ОН	2021 ОН	2022 ОН
Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан	63	72	66
Байнгын /дэд түр/ хороодын хуралдаан	230	266	218
Бусад арга хэмжээ /Намын бүлгийн хуралдаан, ажлын хэсгийн хуралдаан хэлэлцүүлэг, сургалт, мэдээлэл гэх мэт/	257	430	883
<b>НИЙТ</b>	<b>550</b>	<b>768</b>	<b>1167</b>



### 3.3. ХУРАЛДААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

#### А. Хуралдааны техникийн бэлтгэл хангах


Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим болон байнгын хороодын хуралдааны танхимд суурилагдсан хуралдааны цахим систем болон цахим хуралдааны ZOOM программ, MyParliament системийн онлайн санал хураалтын модулийн операторын үйлчилгээг үзүүлж, хуралдааныг дотоод сүлжээний IPTV, [www.parliament.mn](http://www.parliament.mn)

болон [iptv.parliament.mn](http://iptv.parliament.mn) цахим хуудас, Парламентын сэтгүүлчдийн өрөө, телевизийн сувгуудаар шууд дамжуулсан.

Нийт 1300 гаруй удаагийн арга хэмжээний техникийн бэлтгэлийг хангаж, хуралдааны цахим системийн хэвийн, найдвартай ажиллах боломжийг бүрдүүлэн хяналт тавьж ажилласан. **Үүнд:**




#### Б. Операторын үйлчилгээ



#### В. Бусад үйлчилгээ

Хуралдааны бичлэгийг нийт 138 ширхэг Blu-ray дискэнд хуулан хаягжуулж, бүртгэл хөтлөн архивт хүлээлгэн өгсөн. Үүнд:




Дотоод сүлжээний хэрэглэгчдэд зориулан сервер компьютерт 415 ширхэг дууны бичлэг, 568 ширхэг дүрс бичлэгийг тус тус байршуулж, шуурхай ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдааны нийт 2000 гаруй санал хураалтын томъёолол болон 66 удаагийн хуралдааны ирцийн мэдээллийг системийн мэдээллийн санд оруулж хэвлэн, холбогдох нэгжид хүлээлгэн өгсөн. Хуралдааныг сэтгүүлчдийн өрөөнд 600 гаруй удаа, www.parliament.mn цахим хуудсаар 66 удаа шууд

дамжуулсан байна. Цахим хуралдааны программ /Zoom, MyParliament/-ыг ашиглан цахим, танхим хосолсон болон цахим байдлаар нийт 52 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн “Их эзэн Чингис хаан” танхимын орчуулгын системийг 25 удаа, дүрсний зөөврийн системийг “Их Монгол” танхимд 5 удаа, дууны зөөврийн системийг 3 удаа ашигласан байна. Хуралдааны танхимуудад зохион байгуулагддаг арга хэмжээний тоо сүүлийн жилүүдэд тогтмол өсч байна.

### 3.4. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ



Мэдээллийн технологийн засвар үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд программ хангамжийн 725, компьютерын сүлжээний 326, дотоод сүлжээний IPTV-ийн 200, хувилах, хэвлэх төхөөрөмжийн 583 удаагийн засвар үйлчилгээнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, нийт 1053 ширхэг техник хэрэгслийн гэмтлийг оношлон засварлаж хүлээлгэн өгөв. Улсын Их Хурал, Тамгын газрын нийт 414 хэрэглэгчдэд албан ёсны лицензтэй цахим шуудангийн үйлчилгээ үзүүлж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас болон дэд цахим хуудсуудад шинээр орсон 3110 мэдээ, мэдээлэлд форматын хяналт тавьж, дэд цахим хуудас хариуцсан ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж тасалдалгүй, өндөр хурдны суурин интернэтийн үйлчилгээ

авах нөхцөлийг бүрдүүлсэн. Суурин интернэтийн гэрээт урсгал 150MB боловч 650MB урсгал авч байна. Мөн хөдөлгөөнт интернэтийн тасалдалгүй, өндөр хурдтай үйлчилгээ авч, компьютерын дотоод сүлжээний шинэчлэлтийн ажлыг бүрэн хэрэгжүүлж дуусган хэвийн найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Серверийн болон техникийн удирдлагын өрөөнүүдийн цахилгаан, чийг, температур, хөдөлгөөн зэрэг орчны параметрийн үзүүлэлт, мэдээллүүдийг техникийн холбогдох ажилтнууд гар утасны SMS хэлбэрээр хүлээн авч хяналт тавих боломжтой болсон.

Улсын Их Хурлын цахим мэдээллийн системийн үйл ажиллагаа, иж бүрэн байдалд анх удаа үнэлгээ хийж, цахим системүүдийн архитектур, хоорондын уялдаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлов.

## 3.5. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

### УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦАХИМ ШИЛЖИЛТ ХИЙХ, ИННОВАЦ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ, ПАРЛАМЕНТЫН ШИНЭЧЛЭЛИЙГ ҮР ДҮНД ХҮРГЭХ

Цахим парламентын бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлж, Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагааны бүтээмж, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн цахим технологи нэвтрүүлэх, хөгжүүлэлт, хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ үр дүнгээ өгч байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагаанд D-Parliament вэб болон аппликэйшн хосолсон цахим системийг 2022 оны дөрөвдүгээр сараас эхлэн нэвтрүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон боловсруулалтын шатанд байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд иргэдийн саналыг авах, цахим санал асуулга явуулах боломжтой болсон нь хууль тогтоох ажиллагаанд иргэдийн бодитой оролцоог хангасан, ил тод, эргэх холбоотой цахим парламентыг төлөвшүүлэх үйл хэрэгт томоохон дэвшил гарлаа.

Улсын Их Хурлын цахим шилжилтэд гарч буй ийм өөрчлөлт, шинэчлэлтийг үр дүнд хүргэх, цахим парламентын бодлого, зохицуулалтыг тодорхойлж, олон улсын парламентын жишигт нийцсэн шинэ технологи, инновац нэвтрүүлэх, Улсын Их Хурал, Тамгын газрын хэмжээнд мэдээллийн менежментийн үр нөлөө бүхий тогтолцоо бүрдүүлэх зорилготой Тамгын газрын бүтцийн нэгж болох Цахим парламент, инновацын газар байгуулагдаж, мэдээллийн технологийн бодлого, үйл ажиллагааны хүрээ өргөжив.

Тамгын газар 2022 онд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны цахим системийн

шинэчлэлтийн I шатны ажлыг эхлүүлсэн. Хоёр жил гаруй хугацаанд хэрэгжих шинэчлэлийн хүрээнд чуулганы нэгдсэн хуралдааны болон Байнгын хорооны хуралдааны цахим системийг сүүлийн үеийн дэвшилтэт технологи ашиглан иж бүрэн шинэчилж, парламентын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэхээр зорьж байна.

Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас болох [www.parliament.mn](http://www.parliament.mn) хуудсыг Олон Улсын Парламентын Холбооны зөвлөмжид тулгуурлан шинэчилж, цахим мэдээллийн урсгалыг нэмэгдүүлж, хайлтын системийг сайжруулж, агуулгын хайлт, хуулийн сангийн өргөтгөсөн хайлт болон англи хэл, монгол бичгийн хувилбартай болголоо. Мөн мобайл хувилбарыг бий болгосноор Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны онлайн шууд дамжуулалтын чанар дээшилж, бүх төрлийн хөдөлгөөнт төхөөрөмжид хэвийн, найдвартай ажиллах боломжтой болов.

Улсын Их Хурлын цахим мэдээллийн системийн үйл ажиллагаа, иж бүрэн байдалд анх удаа үнэлгээ хийж, цахим системүүдийн архитектур, хоорондын уялдаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлсон нь 2022 оны голлох үр дүнгүүдийн нэг болж байна.

Тамгын газар 2023 онд Улсын Их Хурлын болон Тамгын газрын үйл ажиллагаанд цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр дараах **"зорилт, арга хэмжээ"**-г хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

#### 1. Парламентын цахим шилжилтийг гүнзгийрүүлж, Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологид суурилсан инновац, шинэ технологи нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

- 1.1. D-Parliament цахим системийн хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, хоёр дахь шатны нэмэлт хөгжүүлэлтийг хийнэ.
- 1.2. Улсын Их Хурал, Тамгын газрын мэдээллийн системийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан цахим системүүдийн архитектурт инновац нэвтрүүлэх, технологийн шинэчлэл хийх, цахим шилжилтийг түргэтгэх Private Cloud технологи нэвтрүүлнэ.
- 1.3. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны цахим системийг иж бүрэн шинэчилж, Байнгын хорооны хуралдааны цахим системийн шинэчлэлийг эхлүүлнэ.
- 1.4. Иргэдийн хүсэлт, өргөдөл, гомдлыг цахимаар авдаг E-Petition системийг олон улсын жишиг аргачлалын дагуу хөгжүүлж, ашиглаж эхэлнэ.





## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



### IV БҮЛЭГ

#### УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ПАРЛАМЕНТАД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

- 4.1. Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр
- 4.2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр
- 4.3. Парламентат ёсны талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр
- 4.4. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд үзүүлсэн тусалцаа
- 4.5. Дүгнэлт, зорилт

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ПАРЛАМЕНТАД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

## 4.1. ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Тамгын газар Улсын Их Хурлын ил тод, нээлттэй байдлыг хангаж, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, сурталчлах, хууль, Улсын Их Хурлын шийдвэрүүдийн төсөлд олон нийтийн саналыг авах, батлагдсан хууль тогтоомжийг тайлбарлан таниулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллалаа.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үе шатанд иргэд, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтны талаарх олон нийтийн болон сонирхогч талуудын байр суурийг сонсох зорилгоор Байнгын, дэд, түр хороодоос

өгсөн чиглэлийн дагуу нийтийн сонсголыг 9 удаа, олон нийтийн хэлэлцүүлгийг 77 удаа, хурал, зөвлөгөөнийг 25 удаа, сургалт, семинарыг 19 удаа, уулзалт, ярилцлагыг 247 удаа тус тус зохион байгуулахад Тамгын газраас мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүллээ.

**“Төсөв-2023” хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хүрээнд парламентын түүхэнд анх удаа “D-Parliament” цахим системийг ашиглан иргэд, олон нийтэд Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг танилцуулж, санал авав.**

**“Төсөв-2023” олон нийтийн анхны хэлэлцүүлгийг олон нийтэд сурталчлав.**

### БАЙНГЫН, ДЭД, ТҮР ХОРОО

НИЙТИЙН  
СОНСГОЛ

9



77

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ХУРАЛ  
ЗӨВЛӨГӨӨН

25



247

УУЛЗАЛТ,  
ЯРИЛЦЛАГА

Хэлэлцүүлгийг шууд дамжуулалт (live)-аар хийж, нийт 4 текст мэдээ, 2 инфографик, 6 видео мэдээ, 7 постер бэлтгэн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр шуурхай түгээсэн. Монгол Улсад ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Үндсэн хуулийг боловсруулж, хэлэлцэн баталсан Ардын Их Хурлын депутат, Улсын

Бага Хурлын гишүүд, уг ажилд оролцсон ажлын хэсэг, зохион байгуулах комисс, эрдэмтэн, судлаачдад хүндэтгэл үзүүлж, үйл хэргийг нь сурталчлав.

Энэхүү ажлын хүрээнд “Ардын Их Хурлын депутатууд”, “Үндсэн хууль 30 жил” нэвтрүүлгийг бэлтгэж, 10 телевиз, өдөр тутмын 4 сонин, 12 цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэв.

## 4.2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх ажлын хүрээнд Байнгын хороод, чуулганы нэгдсэн хуралдааны тойм, Улсын Их Хурлын дарга, Байнгын хороодын дарга, гишүүд, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх 748 текст мэдээ бэлтгэж, 45,210 гэрэл зураг ашиглан [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудаст нийтлэв.

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Улсын Их Хурлын ээлжит чуулганы үйл ажиллагааны үр дүн, Улсын

Их Хурлын удирдлагын үйл ажиллагаа, цаг үеийн бусад асуудлаар Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газраас зарласан 89 удаагийн хэвлэлийн бага хурал, 47 удаагийн шууд дамжуулалт (live)-ыг нэвтрүүлж, олон нийтэд хүргэлээ.

2022 онд 13 телевиз, 15 цахим хуудас, өдөр тутмын 4 сонин, 2 радиотой тогтмол хамтран ажиллаж, хэвлэл мэдээллийн 117 байгууллагын 280 ажилтанд парламентын үйл ажиллагааг сурвалжлах үнэмлэх олгон, Улсын Их Хурлын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэв.



Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хороод, Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой хэвлэлийн бага хурал зохион байгуулах, хууль тогтоолын төсөл санаачлагч болон ажлын хэсгийн гишүүд, холбогдох бусад хүмүүсийг хэвлэл

мэдээллийн хэрэгсэлд ярилцлага (49) өгүүлэх ажлыг зохион байгуулж, тухай бүр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг өргөнөөр оролцуулж ажиллав.



748 текст мэдээ | 45,210 гэрэл зураг



89 хэвлэлийн бага хурал | 47 шууд дамжуулалт

Улсын Их Хурал, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын Архангай, Булган, Өвөрхангай аймагт ажилласан, БНТУ, БНСУ-д хийсэн айлчлал, Улсын Их Хурлаас баталсан хуулиуд, Улсын Их Хурлаас зохион байгуулсан нээлттэй сонголын талаар нийт 47 нэвтрүүлэг бэлтгэж, телевизүүдийн эфир, нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэв.

Улсын Их Хурлын долоо хоног тутмын үйл ажиллагааны талаарх 33 тойм нэвтрүүлэг бэлтгэж, телевиз, олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэлээ.

Хууль тогтоох үйл ажиллагаа, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн сурталчилгаа, мэдээллийн цар хүрээг өргөжүүлэн радио сувгаар Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагааны талаар 582 удаагийн товч, шуурхай мэдээг түгээн ажиллав. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудыг 12 удаагийн шууд нэвтрүүлэгт оролцуулж, батлагдсан хууль, Улсын Их Хурлын Тамгын газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар сонсогчдод мэдээлэл хүргэв.

Мөн Монголын үндэсний олон нийтийн радио, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран бэлтгэдэг “Шинэ хууль” нэвтрүүлгийн 10 удаагийн дугаарыг сонсогчдод хүргэлээ.

### Нийгмийн сүлжээний ашиглалт, хандалт

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Parliament.mn цахим хуудас, нийгмийн сүлжээ (twitter.com, facebook.com)-н дэх Улсын Их Хурлын албан ёсны цахим хаягаар дамжуулан олон нийтэд шуурхай хүргэж ажиллав.

**Улсын Их Хурлын фейсбүүк дэх албан ёсны хуудасны дагагчдын тоо өмнөх жилийн мөн үеэс 7000 орчмоор, твиттер дэх дагагчдын тоо 200-гаар тус тус нэмэгдсэн байна.**

Түүнчлэн Улсын Их Хурлын 11 Байнгын хорооны фейсбүүк дэх хуудсыг албан ёсны болгох ажилд туслалцаа үзүүлэн ажиллаж, дээрх хуудсуудаар дамжуулан мэдээ мэдээллийг түгээн ажиллалаа.

Нэвтрүүлгүүдийн зэрэгцээ үйл явдлын 72 постер, 37 инфографик, 241 видео мэдээ, 287 нийгмийн сүлжээний контент, 17 хууль сурталчлах шторкыг бэлтгэн хүргэжээ.







# 72

постер



# 37

инфографик

# 241

ВИДЕО МЭДЭЭ



# 287

контент

# 17

хууль сурталчлах  
шторк



Төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийн сувгийг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Парламентын подкаст” суваг бий болгож, энэ хүрээнд

“Шинэ хууль” аудио подкаст 8, “Тусгаар тогтнолын үнэ цэн” видео подкаст 4, нийт 13 подкаст бэлтгэж [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудсанд байршуулав.

### Хэвлэмэл бүтээгдэхүүн



хос бичгээр буюу монгол бичиг, кирил үсгээр хэвлэж байна. Үндэсний хөтөлбөрийн зорилтод 2022 онд **“Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдэх материалын 30 хүртэл хувийг үндэсний монгол бичгээр хөрвүүлэн хэвлэхээр тусгасан ч нийт 50 дугаарт хэвлэгдсэн нийт хууль, тогтоомжийн 60 хувийг үндэсний монгол бичгээр хэвлэв.**

Парламентын үйл ажиллагааны талаар иргэд олон нийтэд цэгцтэй мэдээлэл, сурталчилгаа хүргэж ажиллав. Энэ хүрээнд “Парламентын боловсрол” сэтгүүл 1900 ширхэгийг хэвлүүлж, Төрийн ордонтой танилцах, “Парламентын боловсрол” хөтөлбөрт хамрагдаж буй сурагч, багш нарт түгээж байна.

# 698

Хууль

# 7

Олон улсын гэрээ, конвенц

# 118

Ерөнхийлөгчийн зарлиг

# 78

Улсын Их Хурлын  
тогтоол

# 52

Засгийн газрын  
тогтоол

# 3

Үндсэн хуулийн цэцийн  
шийдвэр

# 7

Улсын дээд  
шүүхийн тайлбар

**Улсын Их Хурлын 2021 оны намар, 2022 оны хаврын ээлжит чуулганы талаарх олон нийтэд зориулсан эмхэтгэлийг нийт 2700 ширхэг хэвлүүлэн иргэдэд хүргэсэн.**

### 4.3. ПАРЛАМЕНТАТ ЁСНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Улсын Их Хурлын Тамгын газар хүүхэд, залуучуудад парламентын боловсрол олгоход чиглэсэн “Парламентын боловсрол” хөтөлбөрийг 2021 оноос амжилттай хэрэгжүүлж байна. Өсвөр үеийнхэнд зориулан боловсруулж, хэрэгжүүлж байгаа “Парламентын боловсрол” хөтөлбөр нь ардчиллын мөн

чанар, парламентын засаглалын онцлог, хуультогтоохбайгууллагынүйлажиллагаа, хууль тогтоомжийг хэрхэн боловсруулж, баталдаг, мөн түүнийг хэрэгжүүлэхийн утга учрын талаарх мэдлэг олгох, шийдвэр гаргахад оролцох чадвартай, хүний эрхийн мэдрэмжтэй, нийгмийн хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой юм.

#### “Парламентын боловсрол” хөтөлбөрийн хүрээнд:

“Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн Боловсролын газар, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Парламентын боловсрол-Сургагч багш”

дэд хөтөлбөрийг 2022 оны 8 дугаар сараас 12 дугаар сарын хооронд амжилттай зохион байгуулж, хөтөлбөрт нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 62 сургуулийн 102 багшийг хамруулсан.

**102** БАГШ

ДӨРВӨН САРЫН ХУГАЦААНД

НИЙСЛЭЛИЙН 9 ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 62 СУРГУУЛЬ БОЛОН ДЭЛХИЙН 21 УЛС ОРОНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ 61 МОНГОЛ СУРГУУЛИЙГ ТӨЛӨӨЛСӨН.

**1600+** БАГШ, СУРАГЧИД

ТӨРИЙН ОРДНЫ “СОЁМБО” КИНО ТАНХИМААР НИЙТ 1600 ГАРУЙ БАГШ, СУРАГЧИД “ПАРЛАМЕНТЫН БОЛОВСРОЛ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАВ.

“Парламентын боловсрол-Сургагч багш” хөтөлбөрийн хүрээнд “Парламентын боловсрол” хөтөлбөрийг нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтэс, сургуулиудад танилцуулах, парламентын боловсрол олгох сургагч багш бэлтгэх арга зүйн сургалтыг зохион байгуулах, сургагч багш нарын сүлжээ үүсгэх, багш

нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, сургагч багш бэлтгэх сургалтын модуль боловсруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах сургагч багш нарын сүлжээ бий болж, харилцан туршлага солилцох механизм бүрдүүлэх эхлэлийг тавив.



“Парламентын боловсрол-Сургагч багш” хөтөлбөрийн оролцогчдод батламж гардууллаа.

## “Өсвөрийн парламент 2022” хөтөлбөрийн хүрээнд:

2022 ОНЫ СЭДЭВ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ,  
БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ  
ХЭРЭГЛЭЭ

20+ СУМДААС

91 СУРАГЧ

“Парламентын боловсрол” хөтөлбөрийн хүрээнд “Өсвөрийн парламент хөтөлбөр”-ийг Улсын Их Хурал, түүний

Тамгын газраас хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулж байна.



“Өсвөрийн парламент-2022” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа

Парламентын боловсрол олгох үйл ажиллагаагаар дамжуулан Монгол орны өнцөг булан бүрийн хүүхэд залуусыг нэгтгэх, тэдний дуу хоолой, оролцоог шийдвэр гаргах түвшинд хүргэх, нийгэмдээ эергээр нөлөөлдөг, нээлттэй сэтгэлгээтэй, хариуцлагатай, идэвхтэй,

дэлхийн иргэн болгож төлөвшүүлэх зорилготой, 9-11 дүгээр ангийн сурагчдыг хамруулсан “Өсвөрийн парламент 2022” хөтөлбөрт хамрагдахаар материал ирүүлсэн сурагчдаас 91 сурагч шалгарч, хөтөлбөрт хамрагдав.

## “Парламентын боловсрол” илтгэх ур чадвар, мэтгэлцээн



“Парламентын боловсрол” илтгэх ур чадвар, мэтгэлцээний оролцогчид УИХ-ын даргын хамт

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” дэд төсөл, Монголын Карл Попперын Мэтгэлцээний нийгэмлэг хамтран сурагчдын дунд “Парламентын боловсрол” сэдэвт илтгэх ур чадвар, мэтгэлцээний тэмцээнийг

2022 оны 5 дугаар сарын 28-наас 30-ны өдрүүдэд зохион байгуулж, аваргын төлөө мэтгэлцэх төгсгөлийн шатны шалгаруулалт 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Төрийн ордонд боллоо.

Энэ удаагийн мэтгэлцээнд нийт 64 багийн 192 сурагч оролцсон байна.

### **Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой иргэд, зочдыг танилцуулах арга хэмжээ**



Иргэдийг Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцуулах арга хэмжээг иргэдэд хүртээмжтэй, сонирхолтой байх шинэлэг агуулгаар баяжуулан, цар хүрээг нь өргөжүүлэхэд анхаарав.

2022 оны хаврын чуулганаас эхлэн Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой иргэд танилцах үйл ажиллагаанд Улсын Их Хурлын гишүүдийн оролцоог хангаж, гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгдөг болов. Энэхүү үйл ажиллагаанаас

“Иргэдэд нээлттэй Төрийн ордон” шинэ контентийг нэвтрүүлэн, 27 видео контент бэлтгэж, олон нийтийн хүртээл болгосон нь Улсын Их Хурлын Тамгын газраас гаргаж буй контентуудаас хамгийн өндөр хандалт авдаг, түгээгддэг контент болоод байна. Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцах журмын дагуу 2022 оны 03 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 30-ны хооронд 1732 удаагийн аяллаар 33,314 иргэн Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцсан нь өмнөх онуудаас эрс нэмэгдсэн үзүүлэлт болсон.

### **Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төв байгуулах арга хэмжээ**

Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, мөн Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд таниулан сурталчлах зорилгоор Баянхонгор, Өвөрхангай аймагт “Хууль тогтоомж сурталчлах төв” байгуулах бэлтгэлийг хангав. Тус төвн аймагийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд ажиллах бөгөөд 2023 онд зарим аймгуудад үе шаттайгаар нэмж байгуулахаар төлөвлөж байна.




*Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.*

## 4.4. УЛСЫН ИХ ХУРАЛД ИРГЭД, СОНГОГЧДООС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

2022 онд иргэдээс Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодод хандаж 13572 иргэн (давхардсан тоогоор)-ээс нийт 3130 өргөдөл, гомдлыг ирүүлжээ. 2021 онд 2645 өргөдлийг Улсын Их Хурлын хаягаар ирүүлж байсан бол 2022 онд уг тоо 18 хувиар өссөн байна. Ирүүлсэн 3130

өргөдлийн 229 буюу 7,4 хувь нь гомдол, 418 буюу 13,4 хувь нь иргэдийн санал, 275 буюу 8,8 хувь нь улс төр, нийгмийн асуудлаар гаргасан шаардлага, 2208 буюу 70,8 хувь нь хувийн асуудлаар гаргасан өргөдөл байна.

**Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, шаардлага**



Нийт өргөдлийн 1652 буюу 52,8 хувь нь Улаанбаатар хотын иргэдээс, 680 буюу 21,8 хувь нь хөдөө орон нутгийн иргэдээс ирсэн бол 798 буюу 25,4 хувийг хаяг тодорхойгүй өргөдөл эзэлж байна.

2022 онд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод 3130 өргөдөл, гомдлоос 1530 буюу 48,9 хувийг шийдвэрлэсэн нь 2021 оны өргөдөл шийдвэрлэлтийн үзүүлэлтээс 4,4 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үед 2645 өргөдлөөс 1178 буюу 44,5 хувийг шийдвэрлэсэн үзүүлэлттэй байв.



ИРГЭД, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ТӨВ 11-11

www.11-11.mn

# 853

ИРГЭН

Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн цахим хуудсаар дамжуулан Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг бусад байгууллагуудад

хандан нийт 853 иргэнээс санал, гомдол, шүүмжлэл, хүсэлт ирүүлснийг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

## 4.5. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

### НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД, ИРГЭДИЙН ИТГЭЛ ХҮЛЭЭСЭН ПАРЛАМЕНТЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

Тамгын газар Улсын Их Хурлын ил тод, нээлттэй байдлыг хангаж, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, сурталчлах, хууль, Улсын Их Хурлын шийдвэрүүдийн төсөлд олон нийтийн саналыг авах, батлагдсан хууль тогтоомжийг тайлбарлан таниулахад анхаарч ажиллалаа.

Байнгын, дэд, түр хороодоос өгсөн чиглэлийн дагуу нийтийн сонсголыг 9 удаа, олон нийтийн хэлэлцүүлгийг 77 удаа, хурал, зөвлөгөөнийг 25 удаа, сургалт, семинарыг 19 удаа, уулзалт, ярилцлагыг 247 удаа зохион байгуулж хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үе шатанд иргэд, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хурлаас томилогдох албан тушаалтны талаарх олон нийтийн болон сонирхогч талуудын байр суурийг сонсоход Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлсэн байна.

Байнгын хороод, чуулганы нэгдсэн хуралдааны тойм, Улсын Их Хурлын дарга, Байнгын хороодын дарга, гишүүд, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх 748 мэдээ бэлтгэж, 45,210 гэрэл зураг ашиглан [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудаст нийтэлж, Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж ажиллалаа.

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Улсын Их Хурлын ээлжит чуулганы үйл ажиллагааны үр дүн, Улсын Их Хурлын удирдлагын үйл ажиллагаа, цаг үеийн бусад асуудлаар Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газраас зарласан 89 удаагийн хэвлэлийн бага хурал, 47 удаагийн шууд дамжуулалт (live)-ыг олон нийтэд хүргэлээ.

2022 онд Парламентын боловсрол хөтөлбөр хүрээгээ тэлж, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Увс, Ховд аймагт парламентын боловсролын өдөр

арга хэмжээг зохион байгууллаа. Мөн тус хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах Сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг 4 сарын хугацаанд зохион байгуулж, нийслэлийн ерөнхий боловсролын 62 сургууль болон хилийн чанад дахь Монгол сургуулиудын холбооны төлөөлөл 102 багшийг хамруулсан нь “Парламентын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлж, бэлтгэсэн үр дүнтэй ажил болов.

Мөн Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 9-11 дүгээр ангийн 91 сурагчдыг хамруулсан “Өсвөрийн парламент” хөтөлбөр хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Улсын Их Хурал, Тамгын газраас үндэсний хэмжээнд зохион байгуулдаг тус хөтөлбөр 2022 онд “Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй ногоон амьдралын хэв маяг” сэдвийн хүрээнд хэрэгжиж, оролцогчид зургаан долоо хоногийн туршид парламентын боловсрол олгох чиглэлээр 6 сэдвийн хүрээнд сургалт, үйл ажиллагаанд хамрагдаж, парламентын үйл ажиллагаа, түүнд хэрхэн оролцох талаарх мэдлэг, чадвараа нэмэгдүүлэв.

“Хууль тогтоомж сурталчлах төв”-ийг Баянхонгор, Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байгуулахаар шийдвэрлэж, бэлтгэл ажлыг хангаснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төв байгуулж, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбон хууль тогтоомжийг сурталчлах ажлыг үр нөлөөтэй зохион байгуулах Улсын Их Хурлын стратегийн зорилт хэрэгжиж эхэллээ.

Тамгын газар 2023 онд Улсын Их Хурлын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах, парламентад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх чиглэлээр дараах **“зорилт, арга хэмжээ”**-г хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

**1. Улсын Их Хурлын мэдээлэл сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагааны нэгдсэн бодлогыг тодорхойлж, олон нийттэй харилцах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ.**

- 1.1. Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажилд шинэлэг арга барил нэвтрүүлнэ.
- 1.2. Нийгмийн сүлжээний контент боловсруулах, бэлтгэх, түгээх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

**2. Хууль тогтоох, хянан шалгах үйл явцад олон талт оролцоог хангахад тохирсон арга хэрэгслийг нэвтрүүлж, хууль тогтоомжийн албан ёсны эх сурвалжаар хангах үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

- 2.1. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдаан, нийтийн сонсгол, хэлэлцүүлэг, бусад үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй хүргэх ажлыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэнэ.
- 2.2. "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн дижитал хувилбарыг шинэчлэн сайжруулж, хууль тогтоомжийн албан ёсны эх сурвалжаар хангах үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**3. "Парламентын боловсрол" хөтөлбөрийг шинэлэг агуулгаар баяжуулж, хүрээг өргөжүүлэн, орон нутагт "Хууль тогтоомж сурталчлах төв"-үүдийг байгуулна.**

- 3.1. "Парламентын боловсрол" хөтөлбөрийн агуулга, хамрах хүрээг тэлж ерөнхий боловсролын сургуулийн багш, сургуулийн удирдах ажилтанд зориулсан төрөлжсөн сургалтын хөтөлбөртэй болж, багшийн мэргэжил дээшлүүлэх албан ёсны сургалт байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2. "Хууль тогтоомж сурталчлах төв"-ийг гурваас доошгүй аймаг, дүүрэгт шинээр байгуулж хууль тогтоомж, Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмжийг дээшлүүлнэ.







## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



## V БҮЛЭГ

### ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

- 5.1. Судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангахтай холбоотой үйл ажиллагаа
- 5.2. Парламентын сургалт
- 5.3. Парламентын номын сан
- 5.4. Дүгнэлт, зорилт

**5.1. СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГААГААР ХАНГАХТАЙ ХОЛБООТой ҮЙЛ АЖИЛЛАГАА**



Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах явцад судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангах чиг үүргийнхээ хүрээнд Тамгын газраас нийт 50 судалгааны ажил гүйцэтгэлээ. Үүнээс Улсын Их Хурлын гишүүдийн захиалгаар 40, Тамгын газрын удирдлагын захиалгаар болон Хүрээлэнгийн санаачилгаар 10 судалгааны ажил хийсэн. Судалгааны бүтээгдэхүүний төрлөөр авч

үзвэл, харьцуулсан судалгаа 27, мэдээлэл лавлагаа 12, тойм судалгаа 11-ийг бэлтгэсэн байна.

**Эрхлэн гаргасан ном, товхимол, сэтгүүл:**

Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны бүтээмжийг сайжруулах зорилгын хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэв.  
**Үүнд:**

Бүлэг 5



- ☑ “Парламентын судалгаа, шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл, дугаар 4;
- ☑ “Парламентын судалгаа, шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл, дугаар 5 (Тусгай дугаар) Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “Үндсэн хууль-30 жил” эрдэм шинжилгээний хурлын болон 1992-1996 оны анхны Улсын Их Хурлын 30 жилийн ойд зориулсан илтгэлүүдийн эмхэтгэл;
- ☑ Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы танилцуулга, 2022 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагаа болон хүндэтгэлийн хуралдааны танилцуулга (нэгтгэн гаргасан)
- ☑ Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга (нэгтгэн гаргасан)



- ☑ Монгол Улсын Их Хурлын 2022 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагааны танилцуулга (нэгтгэн гаргасан)
- ☑ Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын лавлагаа №1 (2022 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар)
- ☑ Хүрээлэнгийн судалгааны мэдээллийн сангийн лавлагаа №28 (2009-2022 оны 03 дугаар сарын 13-ны байдлаар)
- ☑ Хүрээлэнгийн судалгааны мэдээллийн сангийн лавлагаа №29 (2009-2022 оны 09 дүгээр сарын 27-ны байдлаар)



- “Парламент” Судалгааны эмхэтгэл: боть – 36
- “Парламент” Судалгааны эмхэтгэл: боть – 37
- “Парламент” Судалгааны эмхэтгэл: боть – 38
- “Парламент” Судалгааны эмхэтгэл: боть – 39
- “Парламент” Судалгааны эмхэтгэл: боть – 40
- “Парламент” Судалгааны эмхэтгэл: боть – 41

Түүнчлэн Улсын Их Хурлаар хэлэлцэж буй асуудалд хамаарах судалгаа, мэдээлэлд тулгуурлан “Мэдээлэл

судалгаа” аналитик тойм сэтгүүлийн нийт 14 дугаарыг эрхлэн гаргав. **Үүнд:**

- Шийдвэр гаргах үйл явц дахь олон нийтийн оролцоо (дугаар 34)
- Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт (дугаар 35)
- Органик хүнс (дугаар 36)
- Тэтгэврийн хуримтлалын тогтолцоо (дугаар 37)
- Цалин хөлс (дугаар 38)
- Түгээмэл тархацтай ашигт малтмал (дугаар 39)
- Тэгш хамруулан сургах боловсрол (дугаар 40)
- Төрийн худалдан авах ажиллагааны бодлого (дугаар 41)
- Дуу чимээний бохирдол (дугаар 42)
- Оршуулгын зан үйлийн зохицуулалт (дугаар 43)
- Төрийн сүлдний уламжлал, бэлгэдэл (дугаар 44)
- Цагийн ажил эрхлэлт (дугаар 45)
- Шүүхийн шинжилгээ (дугаар 46)
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зохицуулалт (дугаар 47)

### **Эрдэм шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэв.**

Хууль тогтоох үйл ажиллагааг судалгаа, шинжилгээнд суурилсан мэдээллээр хангах, хууль тогтоомжийн практик үр нөлөө, шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулахад эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс Шинжлэх ухааны академи

болон түүний харьяа судалгааны хүрээлэн, төрийн өмчит их, дээд сургуулиуд болон бусад судалгаа, сургалтын байгууллагын удирдлагууд, эрдэмтэн, судлаачидтай “Эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаа-2022” сэдэвт уулзалтыг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа.

## “Үндсэн хууль-30 жил” ойн арга хэмжээ

Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Үндсэн хууль-30 жил” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний хурлаар 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилт, хэрэгжилтийн явцад үүдэн гарч буй үр дагавар, ололт амжилт, сорилтын талаар судалгаанд суурилсан илтгэлүүдийг хэлэлцэж, тодорхой санал дүгнэлт гаргахын зэрэгцээ Үндсэн хуулийн шинэчлэл, цаашид боловсронгуй болгох асуудлуудын талаар эрдэмтэн судлаачдын санаа бодлыг

сонссон бөгөөд хурлын материалыг эмхэтгэн “Парламентын судалгаа шинжилгээ” сэтгүүлийн тусгай дугаарт хэвлүүлсэн. Эрдэм шинжилгээний хуралд Үндсэн хууль тогтоогчид, судлаачид, хууль зүйн болон бусад салбарын эрдэмтэн судлаачид нийт 100 гаруй хүн биеэр болон цахимаар оролцов.

Мөн уг арга хэмжээний хүрээнд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын ивээл дор Шатар сонирхогчийн улсын аварга шалгаруулах 10 дахь удаагийн тэмцээнийг Монголын шатрын холбоотой хамтран зохион байгууллаа.



“Үндсэн хууль-30 жил” эрдэм шинжилгээний хурлын үеэр

## 5.2. ПАРЛАМЕНТЫН СУРГАЛТ

Улсын Их Хурлын гишүүд, түүний ажлын албаны ажилтнууд болон Улсын Их Хурлын Тамгын газрын нийт ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, холбогдох ном, эмхэтгэл, гарын авлагаар хангах чиг үүргийн хүрээнд нийт 45 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион


байгуулж нийт 2100 хүн (давхардсан тоогоор) хамруулав. Өмнөх онтой харьцуулахад танхимын сургалтын тоо нэмэгдсэн бөгөөд 2022 онд сургалтын 95,5 хувь нь танхимаар, 4,5 хувь нь цахимаар зохион байгуулагдав.

### Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан мэдээлэл сургалт:

- 2022.01.13 -ны өдөр “Үндсэн хууль-30 жил” Эрдэм шинжилгээний хурал
- 2022.01.17-ны өдөр “Япон лугаа адил хөгжье” хэлэлцүүлгийн хүрээнд “Төрийн албаны тогтолцоо ба төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт хэлэлцүүлэг
- 2022.03.04-ний өдөр Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран “Улс төрийн намын эрх зүйн шинэтгэл” хэлэлцүүлэг;
- 2022.05.03-ны өдөр БНОУХ-тай хамтран “Хууль тогтоох үйл ажиллагааны ил тод байдал ба шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо” сэдэвт туршлага солилцох хэлэлцүүлэг;

- “Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага”, “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл” судалгааны танилцуулга
- 2022.07.07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын гишүүнд зориулсан чиглүүлэх мэдээлэл, “Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа ба Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх” сургалтын дэд хөтөлбөр, гарын авлагын танилцуулга;
- 2022.09.07-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран “Эмэгтэй парламентчдын чуулган-2022” анхдугаар чуулган
- 2022.09.08-ны өдөр Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга нарт зориулсан мэдээлэл солилцох уулзалт;
- 2022.11.28-ны өдөр БНОУХ-тай хамтран “Жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах нь” сэдэвт туршлага солилцох хэлэлцүүлэг.

### Тамгын газрын ажилтны сургалт:



### Парламентын сургалтын цахим системийг нэвтрүүлж, хөгжүүлэх ажлын хүрээнд:

Сургалтын 15 сэдвийн хүрээнд 45 дэд сэдэв бүхий цахим хичээлийг Байгууллагын нөөцийн удирдлагын систем ERP-д байршуулж, эргэлтэд оруулав.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтэд нээлттэй цахим сургалтын платформ (MOOC)-оос ардчилал, хүний эрх, жендэрийн сургалтын холбоосыг байршуулсан:

1. EDX/Federica, Columbia, Harvard их сургуулиудаас санал болгодог

Ардчиллын цахим сургалт;

2. EDX/Federica, Columbia, Stanford, Harvard их сургуулиудаас санал болгодог Жендэрийн цахим сургалт;
3. EDX /FedericaX/-аас санал болгодог Улс төрийн талаарх цахим сургалт;
4. Youth for Human Rights International олон улсын байгууллагаас санал болгодог Хүний эрхийн талаарх цахим сургалт.

### Сургалтын цогц хөтөлбөр боловсруулах хүрээнд:

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн

даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 164 дүгээр захирамжаар баталсан “Парламентын сургалтын цогц хөтөлбөр”-ийн хүрээнд 13 дэд хөтөлбөр боловсруулж батлуулсан. Үүнд:

№	ЦОГЦ ХӨТӨЛБӨР	ДЭД ХӨТӨЛБӨР
1.		Улсын Их Хурлын гишүүнд зориулсан чиглүүлэх мэдээлэл, сургалт
2.	Улсын Их Хурлын гишүүний сургалт	Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан мэргэжлийн хөгжлийг дэмжих мэдээлэл, сургалт: "Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа ба Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх"
3.		Тамгын газрын шинэ ажилтанд зориулсан чиглүүлэх сургалт
4.	Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын сургалт	МХДС: Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй
5.		МХДС: Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй
6.	Хуулийн төсөл боловсруулагчдыг бэлтгэх сургалт (Lawmaker training)	Анхан шатны хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх сургалт
7.		Ахисан шатны хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх сургалт
8.	Салбар дундын мэдлэг олгох сургалт	Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, геополитик
9.		Инновац, цахим бодлого
10.		Хүний эрхэд суурилсан хандлага
11.	Нийгмийн мэдрэмж олгох сургалт	Жендэрийн мэдрэмж
12.		Нийгмийн сэтгэл зүй
13.	Хувь хүний хөгжлийн	Монгол хэл, бичиг, найруулга зүй

Мөн дээрх дэд хөтөлбөрүүдээс Монгол Улсын хууль тогтоох үйл ажиллагаа ба Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, Хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх анхан шатны сургалт, Хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх ахисан шатны

сургалтын дэд хөтөлбөрүүдийн агуулгыг Швейцарын хөгжлийн агентлагийн "Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь" дэд төсөл, Азийн сангийн дэмжлэгтэйгээр боловсруулав.


### 5.3.ПАРЛАМЕНТЫН НОМЫН САН

Тус номын сан Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний 5.1.3-т заасан "Парламентын номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж, уншлагын, цахим мэдээлэл, лавлагааны үйлчилгээ

үзүүлдэг болгох" зорилтыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Парламентын номын сан 2022 онд 554 уншигчид 1281 ном гэрээр олгож, 62 уншигчид 188 тогтмол хэвлэлийн нэгжээр үйлчилсэн байна.

Тогтмол хэвлэлийн уншлага үйлчилгээ



Улсын Их Хурлын 2022 оны хавар, намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлаар Парламентын номын санд буй ном, товхимол (725), тогтмол хэвлэл (15)-ээс нийт 1176 мэдээллийг шүүн, ном зүйн лавлагааг 6 удаа боловсруулан, хөдөлгөөнт оффисын "MyParliament" цахим систем, Улсын Их Хурлын цахим хуудас, байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP)-д байршуулж сурталчилсан.

Мөн номын санд шинээр ирсэн номын мэдээг 6 удаа гаргаж уншлагын танхимд дэлгэн, хөдөлгөөнт оффисын

"MyParliament" цахим систем, Улсын Их Хурлын цахим хуудас, байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP)-д тус тус байршуулан уншигчдад сурталчлав.

Цахим каталог ([catalog.parliament.mn](http://catalog.parliament.mn))-т 1135 ном, тогтмол хэвлэлийг оруулж, 1267 номын 812 бичлэгийг засварласан бөгөөд 1186 удаа лавлагаа, ном зүйн үйлчилгээг үзүүллээ.

2022 онд 175 нэрийн 6,5 сая төгрөгийн шинэ ном худалдан авч, сан хөмрөгөө баяжуулав.

### "Номын баяр-2022" арга хэмжээ



"Номын баяр-2022" арга хэмжээний үеэр

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17-д заасан "Үндэсний ном, бичиг соёлын өдрүүд"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд Д.Сүхбаатарын талбай дээр 2022 оны 09 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор зохион байгуулагдсан "Номын баяр-2022" арга хэмжээний үеэр Монгол Улсын Үндсэн хуультай холбогдолтой 200 гаруй нэрийн ном, товхимлоор сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж, парламентын номын сангийн үйл ажиллагааг сурталчлав. Номын үзэсгэлэнг 6000 гаруй хүн үзэж сонирхлоо.



УИХ-ын даргын ивээл дор зохион байгуулагдсан "Номын баяр-2022" арга хэмжээ

## 5.3. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

### ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН СУДАЛГАА, ЛАВЛАГААГААР ХАНГАХ

Тамгын газар 2022 онд Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүдийн захиалга болон цаг үеийн төлөвлөгөөт ажлын хүрээнд нийт 50 судалгааны ажил эрхлэн гүйцэтгэж, Улсын Их Хурлаас хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд судалгаа шинжилгээ, лавлагаа, мэдээллээр шуурхай хангаж ажиллалаа.

Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн үйл ажиллагааг парламентын судалгааны албадын олон улсын сайн туршлага, ОУПХ (IPU)-ноос гаргасан зөвлөмж, гарын авлагад нийцсэн байдлаар зохион байгуулах чиглэлд ахиц гарч, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, тавигдах шаардлага, үйл ажиллагааны зохион байгуулалт тодорхой боллоо.

Хүрээлэнгээс бусад эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтарч ажиллах, эрдэмтэн судлаачдыг хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд татан оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачдын мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлсэн. Үүний үр дүнд бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх, хууль тогтоомжийн

хэлэлцүүлэг, хуулийн төслийн ажлын хэсэгт тухайн салбараар мэргэшсэн эрдэмтэн судлаачид, мэргэжлийн экспертүүдийг татан оролцуулах нөхцөл бүрдсэн юм.

Тус хүрээлэнгийн сургалтын албанаас парламентын сургалтын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд нийт 13 дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлснээр Тамгын газрын ажилтнуудыг мэдээллээр хангах, чадавхжуулах тогтолцоо бүрдэх үндэс суурь тавигдав.

2022 онд Парламентын номын сангийн бүтэц, орон тоог шинэчлэн хүний нөөцийг бэхжүүлж, Номын сангийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах, үйлчилгээний журмыг шинэчлэн сайжруулах ажлыг эхлүүлсэн. Номын сангийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хууль тогтоогчид, хуулийн төсөл боловсруулагчид номын сангийн үйлчилгээг түргэн шуурхай авах, олон талт эх сурвалжийн мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлж, номын сангийн цахим шилжилтийг эрчимжүүлэхэд томоохон түлхэц үзүүлэх юм.

Тамгын газар 2023 онд парламентын судалгаа, сургалт, мэдээллийн чиглэлээр дараах **“зорилт, арга хэмжээ”**-г хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

#### 1. Парламентын судалгааны гүйцэтгэлийн чанарыг сайжруулж, ижил төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай судалгааны мэдээлэл солилцох тогтолцоо бүрдүүлнэ.

- 1.1. Судалгааны гүйцэтгэлийн чанарыг сайжруулж, захиалагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн судалгаа, мэдээллээр уян хатан, шуурхай хангаж ажиллана.
- 1.2. Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн судалгааны мэдээллийн сангийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлж, судалгааны бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан, хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 1.3. “Шинэ сэргэлт-эрх зүйн шинэчлэл”-ийн бодлогын хүрээнд холбогдох багц хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахад шаардлагатай шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хууль тогтоогчдыг шуурхай хангаж ажиллана.



**2. Парламентын сургалтын цогц хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хүний нөөцийн хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд Тамгын газрын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.**

- 2.1. Парламентын сургалтын цогц хөтөлбөрт тусгагдсан 10-аас доошгүй сургалтын дэд хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангах замаар Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 2.2. Парламентын сургалтын цахим системийн ашиглалтыг сайжруулах, ажилтнуудад цахим сургалтын системийн хэрэглээг хэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 2.3. Хуулийн төсөл боловсруулах ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр хуулийн төсөл боловсруулагчдад эзэмшвэл зохих онолын болон практик мэдлэг олгох, хууль зүйн техникийн суурь мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын шинэ механизм бүрдүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

**3. Парламентын номын сангийн хөгжлийг шинэ шатанд гаргах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.**

- 3.1. Парламентын номын сангийн үйлчилгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хөгжлийн стратегийг шинээр тодорхойлж, хэрэгжүүлж эхэлнэ.
- 3.2. Парламентын номын сангийн үйлчилгээг олон улсын туршлага, холбогдох стандартад нийцүүлэх чиглэлээр инновац нэвтрүүлж, хэрэгжилтийг хангана.
- 3.3. Цахим номын сангийн дэд бүтэц, нөөцийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн соёл, танин мэдэхүйн шинэлэг хөтөлбөр, арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж хэвшинэ.





## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



### VI БҮЛЭГ

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

- 6.1. Улсын Их Хурал, түүний Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах чиглэлээр
- 6.2. Олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр
- 6.3. Гадаад харилцааны асуудлаар зөвлөгөө өгөх, лавлагаа, мэдээ, танилцуулгаар хангах чиглэлээр
- 6.4. Тамгын газрын хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр, хэрэгжилт
- 6.5. Дүгнэлт, зорилт

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

## 6.1. УЛСЫН ИХ ХУРАЛ, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗРЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Улсын Их Хурал, Монголын Парламентын бүлгэм, Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах чиглэлээр нийт 12 харилцан айлчлалын бэлтгэл ажлыг хангаж ажиллав. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсад, Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан тэргүүтэй төлөөлөгчид Европын парламент, Бельгийн Хаант Улс, Люксембургийн Их Гүнт Улсад тус тус айлчлал хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын урилгаар БНХАУ-ын

БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жанышу, Канад Улсын Парламентын Сенатын танхимын дарга Жорж Ж.Фюри, Шведийн Хаант Улсын Риксдаг (парламент)-ийн Тэргүүн дэд дарга хатагтай Оса Линдестам, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын орлогч дарга Ш.В.Кара-Ооль, БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн байнгын хорооны дарга, Лаос-Монголын парламентын бүлгийн дарга Вонсаг Пантавон, Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Япон-Монголын парламентын бүлгийн дарга Мотоо Хаяши нар Монгол Улсад айлчлал хийв.

### ГАДААД АЙЛЧЛАЛЫН ХҮРЭЭНД:

#### Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын Бүгд Найрамдах Турк Улсад хийсэн албан ёсны айлчлал

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Бүгд Найрамдах Турк Улс (БНТУ)-ын Үндэсний Их Хурлын дарга Мустафа Шентопын урилгаар 2022 оны 10 дугаар сарын 13-наас 17-ны өдрүүдэд тус улсад албан ёсны айлчлал хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын албан ёсны айлчлалын үеэр БНТУ-ын Үндэсний Их Хурлын дарга Мустафа Шентоптой албан ёсны хэлэлцээ хийж, БНТУ-ын Ерөнхийлөгч Р.Т.Эрдоганд бараалхаж, Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч З.Арслан, ШУА-ийн Ерөнхийлөгч Музаффер Шекер нартай уулзав. Мөн Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Анкара хотноо зохион байгуулагдсан Монгол, Туркийн бизнес форумын нээлт болон Үндсэн хуулийн шүүхийн шинээр томилогдсон шүүгчийн тангараг өргөх ёслолд тус тус оролцож, Измир хотын Измир Катип Челеби их сургуульд зочилж “Хүндэт доктор”-



Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар БНТУ-ын Үндэсний Их Хурлын дарга Мустафа Шентоп - той албан ёсны хэлэлцээ хийлээ.

ын цол хүртсэн. Айлчлалаар улс төр, парламент, худалдаа, эдийн засаг, зам тээвэр, хөдөө аж ахуй, соёл, боловсрол, шинжлэх ухаан, түүх, археологи зэрэг салбарт хамтран ажиллах асуудлаар яриа хэлэлцээ өрнөсөн нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд дөхөм үзүүлсэн чухал алхам болсон.



Улсын Их Хурлын дарга Измир хотын Измир Катип Челеби Их сургуулийн "Хүндэт доктор" цол хүртэв.



Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч Зүхтү Арслан - тай уулзлаа.

### Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын Бүгд Найрамдах Солонгос Улсад хийсэн айлчлал

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2022 оны 10 дугаар сарын 25-наас 29-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-д ажлын айлчлал хийж БНСУ-ын Үндэсний Ассамблейн дарга Ким Жин Пё-той албан ёсны уулзалт хийв. Талууд Монгол Улс, БНСУ-ын улс төрийн итгэмжилсэн харилцааг бэхжүүлж, харилцааны эрх зүйн орчныг дэмжихэд хоёр улсын хууль тогтоох дээд байгууллага хоорондын хамтын ажиллагаа, хэлхээ холбоо чухал үүрэгтэйг онцолж, хоёр улсын парламентын дарга, дэд дарга нарын түвшинд төдийгүй Байнгын хороод, парламентын найрамдлын бүлгийн түвшинд харилцан солилцоог дэмжиж,

ажил хэрэгч уулзалт, ярилцлага зохион байгуулж байхаар тохиролцов.

Айлчлалын үеэр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар БНСУ-ын Ерөнхий сайд Хан Дог Сү, Үндэсний Ассамблейн дэд дарга Ким Ён Жү-тэй уулзаж, Монгол Улс, БНСУ-ын Стратегийн түншлэлийн өргөн хүрээтэй асуудлаар дэлгэрэнгүй санал солилцов.

"Бан Ги Мүн" сан, АНУ-ын Стэнфордын Их сургуулиас хамтран зохион байгуулсан "Номхон далайг дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ" олон улсын чуулга уулзалтад үндсэн илтгэгчээр оролцсон.



БНСУ-ын Үндэсний ассамблейн дарга Ким Жин Пё - той уулзаж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцлоо.

## Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан тэргүүтэй төлөөлөгчдийн Европын парламент, Бельгийн Хаант Улс, Люксембургийн Их Гүнт Улсад хийсэн айлчлал



Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан тэргүүтэй төлөөлөгчид Европын Парламент дахь Төв Ази, Монголтой харилцах бүлгийн дарга

Фулвио Мартучиллогийн урилгаар Европын парламент, Бельгийн Хаант Улс, Люксембургийн Их Гүнт Улсад 2022 оны 06 дугаар сарын 12-ноос 20-ны өдрүүдэд ажлын айлчлал хийж Европын Парламентын тэргүүн дэд дарга Отмар Карас, Европын Парламент дахь Монгол Улстай харилцах бүлгийн дарга Фулвио Мартучилло нартай тус тус уулзав. Парламент хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх, цаг үеийн асуудлаар баримталж буй байр сууриа танилцуулахад чухал ач холбогдолтой айлчлал болсон.

## Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Францын парламентын бүлгийн дарга Ж.Чинбүрэн тэргүүтэй төлөөлөгчдийн БНФУ-д хийсэн айлчлал



Бүгд Найрамдах Франц Улс (БНФУ)-ын Сенатын гишүүн, Сенат дахь Франц, Монголын найрамдлын бүлгийн дарга Филип Мүеэгийн урилгаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Францын парламентын бүлгийн дарга Ж.Чинбүрэн тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 02 дугаар сарын 20-ноос 26-ны

өдрүүдэд Франц Улсад ажлын айлчлал хийв. Төлөөлөгчид Үндэсний Ассамблей дахь Франц, Монголын парламентын найрамдлын бүлгийн дарга Ф.Латомб, Сенатын Ерөнхий нарийн бичгийн дарга Эрик Таверн нартай уулзаж Францын аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийв.

Энэ удаагийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлага багтаж ажилласан нь парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан санал солилцох ач холбогдолтой айлчлал болов. Мөн Монгол Улсад төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй Францын аж ахуйн нэгжүүдээр зочилж үйл ажиллагаатай нь танилцсан явдал нь Улсын Их Хурлын гишүүд илүү тодорхой мэдээлэл авах боломжийг олгосон чухал ач холбогдол бүхий айлчлал болов.

## ДОТООДОД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

### Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга Ли Жанышугийн айлчлал

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга Ли Жанышуг

2022 оны 09 дүгээр сарын 10-наас 12-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жанышу айлчлалынхаа үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд бараалхан, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатартай хэлэлцээ хийж, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэтэй уулзалт хийв. Уулзалтуудаар бүс нутгийн хамтын ажиллагаа, олон улсын тавцан дахь бүс нутаг, тив дэлхийн байгууллагуудын



хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх, бэхжүүлэх, хамтран ажиллах, мөн хоёр талт, олон талт хамтын ажиллагаа, эдийн засаг, улс төр зэрэг сэдвээр санал солилцсон. Тус айлчлал нь хоёр орны харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон.

2022 онд гадаад улс, олон улсын байгууллагын дээд, өндөр түвшний зочид төлөөлөгчид Монгол Улсад айлчилж, Улсын Их Хурлын даргад бараалхав. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гүтэрреш, БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И, ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавров, БНСУ-ын Гадаад хэргийн сайд Пак Жин, БНАЛАУ-ын Ерөнхий сайдын орлогч, Гадаад хэргийн сайд Салемсай Гуммасит, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх, БНСВУ-ын Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн сайд Ле Минь Хоан болон БНТУ, БНСУ, Казахстан Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга нар зэрэг зочид төлөөлөгчид тус тус Улсын Их Хурлын дарга Г.Занданшарт баралхав.

### Канад Улсын Парламентын Сенатын танхимын дарга Жорж Ж.Фюригийн айлчлал



Канад Улсын Парламентын Сенатын танхимын дарга Жорж Ж.Фюри 2022 оны 10 дугаар сарын 08-наас 13-ны өдрүүдэд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын урилгаар албан ёсны айлчлал хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Канад Улсын Парламентын Сенатын танхимын дарга Жорж Ж.Фюри нар албан ёсны хэлэлцээ хийж хоёр улсын харилцааг шинэ түвшинд гаргахад "Иж бүрэн түншлэлийн төлөөх Монгол, Канадын хамтын ажиллагааны Замын зураглал"-ын хэрэгжилтийг хангаж, бодит үр дүнд хүргэхэд хоёр улсын хууль тогтоох дээд байгууллагын зүгээс бүх талын дэмжлэг үзүүлэх талаар ярилцав.


Талууд 2023 онд тохиох Монгол Улс, Канад Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг хамтран тэмдэглэхэд өндөр ач холбогдол өгч, ойн хүрээнд харилцан айлчлал, уулзалтууд, иргэд хоорондын харилцааг өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд зохион байгуулахаар тохиролцов.

## **ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын орлогч дарга Ш.В.Кара-Оолийн айлчлал**

ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын орлогч дарга Ш.В.Кара-Оол тэргүүтэй төлөөлөгчид Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсад айлчлал хийв. Айлчлалын үеэр

төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт бараалхан, Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяатай уулзалт хийж, Үндэсний их баяр наадамд хүндэт зочны хувиар оролцов.

## **Шведийн Хаант Улсын Риксдаг (парламент)-ийн Тэргүүн дэд дарга Оса Линдестамын айлчлал**



Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын урилгаар Шведийн Хаант Улсын Риксдаг (парламент)-ийн Тэргүүн дэд дарга Оса Линдестам тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 05 дугаар сарын 21-нээс 25-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлав. Дэлхий нийтийг

хамарсан КОВИД-19 цар тахлын нөлөө арилаагүй, Орос-Украины дайн өрнөж буй онцлог цаг үед Риксдагийн төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлал нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд Шведийн Хаант Улсын парламентын зүгээс ач холбогдол өгч буйн илэрхийлэл болсон.

Айлчлалын үеэр хийгдсэн албан уулзалтуудад талууд цаашид парламент хоорондын төдийгүй хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар өргөжүүлэн хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж ажиллах эрмэлзлээ харилцан илэрхийлсэн онцлог ач холбогдолтой байв.

## **Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн байнгын хорооны дарга, Лаос-Монголын парламентын бүлгийн дарга Вонсаг Пантавангийн айлчлал**

Дипломат харилцаа тогтоосны түүхэн ойн хүрээнд БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн Батлан хамгаалах, аюулгүй байдлын байнгын хорооны дарга, Үндэсний Ассамблей дахь Лаос-Монголын парламентын бүлгийн дарга Вонсаг Пантаванг тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 09 дүгээр сарын 06-наас 12-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлал хийв.

Монгол Улсад айлчилсан төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт бараалхаж, Монгол Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний симпозиумд оролцов. Уулзалтаар хоёр улсын харилцаа, хууль тогтоох байгууллагуудын хамтын ажиллагааны асуудлуудаар ярилцаж, санал солилцов.

## **Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Япон-Монголын парламентын бүлгийн дарга Мотоо Хаяшигийн айлчлал**

Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Япон-Монголын парламентын бүлгийн дарга Мотоо Хаяши тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 8 дугаар сарын 20-ноос 24-ний өдрүүдэд Монгол Улсад айлчлав.

Япон Улсын парламентаас дипломат харилцааны түүхэн ойд өндөр ач холбогдол өгч, бүлгийн дарга Мотоо Хаяши Япон Улсын парламентын Төлөөлөгчдийн танхим болон Зөвлөхүүдийн танхимын 9 гишүүн, иргэд, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн нийт 86 хүний өргөн бүрэлдэхүүнтэйгээр айлчлал хийв.





Уулзалтын үеэр талууд хоёр улсын улс төр, эдийн засаг, эрчим хүч, хот байгуулалт, тээвэр логистик болон бүс нутаг, олон улсын тавцан дахь хамтын ажиллагаа зэрэг хоёр талын харилцааны олон чухал асуудлаар өргөн хүрээнд ярилцаж, санал солилцов. Монгол Улс, Японы Улсын харилцаанд өнөөг хүртэл хүрсэн ололт амжилтыг бататгах, харилцан ойлголцол, итгэлцлийг улам бүр гүнзгийрүүлэх, парламент хоорондын найрсаг харилцааг бэхжүүлэхэд энэхүү айлчлал чухал ач холбогдолтой болсон.

## ЦАХИМААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

**Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн дарга Сайсумпон Фумвихан-тай хийсэн цахим уулзалт**



Цахим уулзалтын үеэр

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн дарга Сайсумпон Фумвихан-тай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр цахим уулзалт хийв.

Уулзалтын үеэр талууд Монгол, Лаосын эртний түүхэн улбаатай, найрсаг дотно харилцаа, хууль тогтоох дээд байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа өнгөрсөн хугацаанд идэвхтэй хөгжиж ирснийг тэмдэглээд хоёр улсын уламжлалт, найрсаг харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, эрх зүйн орчныг бэхжүүлэхэд хоёр улсын парламент хоорондын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэж ирснийг онцлов.

Лаосын тал уулзалтаар хууль тогтоох

дээд байгууллагуудын хооронд байгуулж байсан хамтын ажиллагааны Санамж бичгүүдийг шинэчлэх, харилцан мэдээлэл, туршлага солилцох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, лаос, монгол хэлний хэлмэрчийг бэлтгэх, өмнө байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд Засгийн газруудыг дэмжих зэргээр хоёр улсын уламжлалт, найрсаг харилцааг өргөжүүлэх талаар байр сууриа илэрхийлэв.

Талууд цаашид хоёр улсын парламент хоорондын хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, парламентын найрамдлын бүлэг хоорондын солилцоог улам эрчимжүүлэхийн төлөө нягт хамтран ажиллахаа нотолж, олон улс, бүс нутгийн түвшинд харилцан нэгнээ дэмжиж ажиллахаа илэрхийлэв.


## 6.2. ОЛОН УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН ПАРЛАМЕНТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

Олон Улсын Парламентын Холбоо, Ази, Номхон далайн орнуудын парламентын форум, бусад олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын нийт 20 хурал,

семинар, хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын төлөөлөгчдийг биечлэн болон цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулав.

### ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

#### Монгол Улс, Европын Парламент хоорондын ээлжит XIV зөвлөлдөх уулзалт



Монгол Улс, Европын Холбоо хоорондын харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хоёр талын дээд, өндөр түвшний улс төрийн яриа

хэлэлцээний давтамжийг гадгалах хэрэгэнд Улсын Их Хурал, Европын Парламентын XIII уулзалтын хэрэгжилтийг дүгнэж, хоёр талын хууль тогтоох байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, Түншлэл, хамтын ажиллагааны Хэлэлцээрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Европын Холбоотой худалдаа, эдийн засгийн харилцааг улам өргөжүүлэх замаар цаашид хоёр талын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргахад түлхэц үзүүлсэн чухал ач холбогдол бүхий уулзалт болов.

### ГАДААДАД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

#### Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын Парламентын Ассамблейн ээлжит уулзалтууд



Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын Парламентын Ассамблейн Өвлийн ээлжит хурал, XXIX хуралдаан, “Терроризмын хохирогчдод үзүүлэх парламентын тусалцаа” олон улсын дээд хэмжээний уулзалт, “Торгоны зам” группийн IV уулзалт зэрэгт Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын ассамблейтай харилцах бүлгийн дарга Д.Цогтбаатар тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

#### Эрүүл мэндийн асуудлаарх Ази-Номхон далайн Парламентын Форумын VI хурал



2022 оны 8 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан Эрүүл мэндийн асуудлаарх Ази-Номхон далайн Парламентын Форумын VI хуралд Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн оролцов. Хурал “COVID-19 цар тахлыг даван туулах нь” сэдвийн хүрээнд гурван салбар хэлэлцүүлэг өрнүүлж,

оролцогчдод Солонгосын Үндэсний эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, их өгөгдөл ашиглан, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн бодлогыг улам сайн ойлгох, хамтын ажиллагааны боломжуудыг

судлах нөхцөл олгосон ач холбогдолтой байв. Хурлын үр дүнд Форумын VII хурал 2023 онд Монгол Улсад “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ” сэдвийн дор зохион байгуулагдахаар тогтов.

### **Олон Улсын Парламентын холбооны Парламентын Ассамблейн 144 дүгээр уулзалт - Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн хурал**

Индонез Улсын Бали хотноо 2022 оны 03 дугаар сарын 18-наас 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ОУПХ-ны Парламентын Ассамблейн 144 дүгээр нэгдсэн хуралдаан – Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн хуралд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

Уулзалтаар мэдээллийн харилцаа холбооны технологийн хөгжүүлэлт, хууль эрх зүйн ил тод байдлын үнэлгээ, парламентын гишүүдийн албан томилолт, парламентын ордныг сэргээн засварлах ажил зэрэг сэдвүүдээр улс орнууд өөрсдийн туршлагаас танилцуулж, харилцан санал солилцов.

### **Парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны шинэ чиглэлийг тодорхойлж, Санамж бичигт гарын үсэг зурлаа**



*Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Солонгос Улсад айлчиллаа.*

Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Солонгос Улсад 2022 оны 05 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын хүрээнд УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан БНСУ-ын Үндэсний Ассамблейн (парламентын) Ерөнхий нарийн бичгийн дарга Ли Чун Суак, Үндэсний Ассамблейн дэргэдэх Төсвийн албаны дарга Лим Ик Санг нартай уулзаж, Тамгын газар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр санал солилцов.

Уулзалтуудын үеэр УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан

хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид бататган хөгжүүлэхэд хууль тогтоох байгууллагын Тамгын газрууд хоорондын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй бөгөөд Монгол Улсын Их Хурал, БНСУ-ын Үндэсний Ассамблейн Тамгын газрууд үр өгөөжтэй хамтран ажиллаж, уулзалт, яриа хэлэлцээ тогтмолжиж буйд баяртай байгаагаа илэрхийллээ. Тэрбээр хамтын ажиллагааны энэхүү сайхан уламжлалыг цаашид шинэ агуулгаар улам баяжуулан хөгжүүлэх, тухайлбал цахим парламент болох, хууль тогтоох үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, технологийн шинэ ололтуудыг ашиглаж буй БНСУ-ын туршлагаас суралцах хүсэлтээ илэрхийллээ.

### 6.3. ГАДААД ХАРИЛЦААНЫ АСУУДЛААР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, ЛАВЛАГАА, МЭДЭЭ, ТАНИЛЦУУЛГААР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

Улсын Их Хурал, түүний Тамгын газраас хөрш, гуравдагч хөрш, түншлэлийн харилцаатай улс орнуудын парламент, тэдгээрийн Тамгын газартай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын даргын 48 захидал, Улсын Их Хурлын гишүүдийн 42 захидал, албан бичиг, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 19 захидал, албан бичиг, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд даргын 12 албан бичиг, захидал зэргийг ёсчлуулж илгээв. Гадаад орнуудын парламент болон олон

улсын байгууллагуудын үйл ажиллагааг судалж, Улсын Их Хурлын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтад Тамгын газрын ажилтнуудыг оролцуулах, харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран сургалт зохион байгуулах боломжийг эрэлхийлэх хүрээнд тодорхой ажлуудыг хийв. Үүнд 9 багц сургалтын саналыг дэвшүүлж, холбогдох газар хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүдийг хамруулах ажлыг зохион байгуулсан.

#### Тамгын газрын гадаад сургалт

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газрын болон Улсын Их Хурлын даргын ажлын алба, Улсын Их Хурал дахь намын бүлгийн Ажлын албаны 81 албан

хаагчид дараах гадаад улсын парламент, олон улсын байгууллагуудад ажиллаж туршлага судлах ажлыг зохион байгуулав.



"Монгол Улсад төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд Швейцарын Холбооны Улсад хийсэн ажлын айлчлал



БНСУ-ын Үндэсний Ассамблейд хянан шалгах үйл ажиллагаа, нийтийн сонсголын чиглэлээр туршлага судлах үйл ажиллагаа

2022.05.11-15 (2)	Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейд төсвийн шинжилгээ болон парламентын судалгааны чиглэлээр
2022.08.15-19 (2)	"Монгол Улсад төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд Швейцарын Холбооны Улсад хийсэн ажлын айлчлал
2022.11.02-12 (5)	Америкийн Нэгдсэн Улсын Конгрессийн "Нээлттэй дэлхий" хөтөлбөр
2022.11.14-17 (5)	Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейд хянан шалгах үйл ажиллагаа, нийтийн сонсголын чиглэлээр
2022.11.28-12.02 (6)	Швейцарын Холбооны Улсын парламентын Тамгын газарт парламентын хяналт шалгалтын чиглэлээр
2022.11.28-12.01 (8)	Олон Улсын Парламентын Холбоонд жөндөрийн мэдрэмж болон хүний эрхийн өөрийгөө үнэлэх үнэлгээний чиглэлээр
2022.12.05-06 (9)	Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейд хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хиймэл оюун ухаанд суурилсан платформ нэвтрүүлэх төсөлтэй танилцах, туршлага судлах үйл ажиллагаа
2022.12.12-2023.12.30 (1)	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (ИТЕС),

## 6.4. ТАМГЫН ГАЗРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, ХЭРЭГЖИЛТ

### “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” дэд төслийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил:

“Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд УИХ-ын хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхийг дээдэлсэн парламентын үйл ажиллагааг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, УИХ-аар хуулийн төсөл хэлэлцэх үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, “Парламентын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлахад дэмжлэг үзүүлэх тэргүүлэх зорилтыг 2022 онд дэвшүүлэн хэрэгжүүлэв.

Тус төслийн хүрээнд Тамгын газрын албан хаагчид 2022 оны 12 дугаар сард БНСУ-ын Үндэсний Ассамблейд төсвийн шинжилгээ, парламентын судалгаа, хиймэл оюун ухаанд суурилсан платформ нэвтрүүлэх төсөлтэй танилцах чиглэлээр, Швейцарын Холбооны Улсын Парламентын тамгын газарт парламентын хяналт шалгалтын чиглэлээр, Олон улсын парламентын холбоонд жендэрийн мэдрэмж болон хүний эрхийн өөрийгөө үнэлэх үнэлгээний чиглэлээр туршлага судалж ажиллав.



*ОУПХ-нд парламентын жендэрийн мэдрэмжтэй байдал болон хүний эрхийн өөрийн үнэлгээ хийх чиглэлээр туршлага судлав.*

“Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхийг дээдэлсэн парламентын үйл ажиллагааг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Улсын Их Хурлаар хуулийн төсөл хэлэлцэх үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, “Парламентын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлахад дэмжлэг үзүүлэх тэргүүлэх зорилтыг 2022 онд дэвшүүлэн хэрэгжүүлэв. Тус төслийн хүрээнд Тамгын газрын албан хаагчид 2022 оны 12 дугаар сард БНСУ-ын Үндэсний Ассамблейд төсвийн шинжилгээ, парламентын судалгаа, хиймэл оюун ухаанд суурилсан платформ нэвтрүүлэх төсөлтэй танилцах чиглэлээр, Швейцарын Холбооны Улсын Парламентын тамгын газарт парламентын



*Швейцарын Холбооны Улсын парламентын Тамгын газарт парламентын хяналт шалгалтын чиглэлээр туршлага судлах үйл ажиллагаа*

хяналт шалгалтын чиглэлээр, Олон улсын парламентын холбоонд жендэрийн мэдрэмж болон хүний эрхийн өөрийгөө үнэлэх үнэлгээний чиглэлээр туршлага судалж ажиллав.

## Азийн сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газартай хамтран хэрэгжүүлсэн ажил:

Улсын Их Хурлын Тамгын газар нь Азийн Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газартай 2021 онд байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэв. Хамтын ажиллагааны хүрээнд Азийн сан нь хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох чиглэлд анхаарч ажиллав.

Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх, Хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Лүндээжанцангийн “Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх”, “Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх” цуврал ботийг боловсруулах, хэвлэх ажилд Азийн сан болон МУПАБ нь төсөлтэй хамтран ажиллаж, цуврал ботийг 2022 оны 07 дугаар сард нийтийн хүртээл болгов. Ингэснээр Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх мэдээлэл, арга зүйн бүтээгдэхүүн, санг нэмэгдүүлсэн бөгөөд цаашид энэ чиглэлээр гарын авлага, мэдээллийн бүтээгдэхүүнийг гаргахаар ажиллаж байна.

Азийн сантай хамтран “Зөвлөлдөх санал асуулга ба цахим хэлэлцүүлэг зохион байгуулах нь” сэдэвт сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулав. Мөн “Харилцаа холбоо болон дижитал хүртээмжийн стратеги” сэдэвт парламентын үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцооны талаар туршлага солилцох вебинарыг 2022 оны 06 дугаар сарын 27, 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав. Вебинарын сэдвийн хүрээнд оролцогчид хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд парламентын боловсрол олгох, цахим парламент бий болгох зорилтын дагуу Олон нийттэй харилцах стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр мэдээлэл, ойлголтоо нэмэгдүүлсэн. Их Британи, Бразил, Эстони Улсын парламент, Засгийн газарт хариуцлагатай алба хашиж байсан туршлагатай мэргэжилтнүүд уг вебинарыг хөтөлж явуулав.

Азийн сангийн дэмжлэгтэйгээр Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга С.Батбаатар тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 12 дугаар сард БНСУ-ын Үндэсний Ассамблейд ажиллав. Үндэсний Ассамблейн Дэгийн газрын дарга Жон Мён Хутай хоёр талын уулзалт хийж, тус улсын Үндэсний Ассамблейн хянан шалгах үйл ажиллагаа, нийтийн сонсголын эрх зүйн зохицуулалттай танилцаж, туршлага судлав.



## 6.4. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

### ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ

2022 онд Улсын Их Хурлын гадаад арга хэмжээ идэвхтэй өрнөж, парламентын гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр өргөжин тэлж 12 харилцан айлчлалыг амжилттай зохион байгууллаа. Мөн энэ онд Тамгын газрын бусад улсын парламентын Тамгын газар, олон улсын болон байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхой болгож, “хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр хариуцсан нэгж”-тэй болсон бөгөөд Улсын Их Хурлын Тамгын газрын болон Улсын Их Хурлын даргын ажлын алба, Улсын Их Хурал дахь намын бүлгийн Ажлын албаны 81 албан хаагчид гадаад улсын парламент, олон улсын байгууллагуудад ажиллаж туршлага судлах ажлыг зохион байгууллаа.

Гадаад орнуудын парламент болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагааг судалж, Улсын Их Хурлын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтад Тамгын газрын ажилтнуудыг оролцуулах, харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран сургалт зохион байгуулах боломжийг эрэлхийлэх хүрээнд тодорхой ажлуудыг

хийж гүйцэтгэлээ.

Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газар нь Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийг хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэв. Мөн Азийн сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, Монгол Улс дахь гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг амжилттай хэрэгжүүлэв.

Улсын Их Хурлын Тамгын газар нь Азийн Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газартай байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох чиглэлд энэ онд түлхүү анхаарч ажилласныг тэмдэглэх нь зүйтэй.

Тамгын газар 2023 онд Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр дараах **“зорилт, арга хэмжээ”**-г хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

#### **1. Монгол Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлэх хүрээнд парламент хоорондын хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргана.**

- 1.1. Хоёр талын Парламентын тэргүүн, дэд дарга, бүлгийн дарга, гишүүдийн урьдчилан төлөвлөсөн харилцан айлчлалуудыг зохион байгуулна.
- 1.2. Бүс нутгийн болон Алтай дамнасан орнуудын парламент, их сургууль, эрдэмтэн судлаачидтай хамтран тогтвортой байдал, жендэр, Урал-Алтай судлалын хэтийн төлөв, хандлагын талаар олон улсын чуулга уулзалтыг эх орондоо зохион байгуулна.
- 1.3. Дэлхийн эрүүл мэндийн асуудлаарх Ази, Номхон далайн бүсийн парламентчдын ээлжит хуралдааныг ДЭМБ-тай хамтран Улаанбаатарт зохион байгуулна.
- 1.4. Улсын Их Хурлын Тамгын газар, Олон Улсын Парламентын Холбоотой 2022 онд байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын ажилтнуудад зориулсан санал солилцох цахим болон биечилсэн семинар, сургалтууд зохион байгуулна.

#### **2. Тамгын газраас техникийн хамтын ажиллагааны талаар баримтлах бодлогыг тодорхойлж, бусад байгууллагатай хамтарсан төсөл хөтөлбөрийн цар хүрээг өргөтгөнө.**

- 2.1. Улсын Их Хурлын Тамгын газрын техникийн хамтын ажиллагааны талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, батална.
- 2.2. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын бусад байгууллагатай хамтарсан төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан төлөвлөж, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.
- 2.3. Олон Улсын Парламентын Холбооны хүний эрх, жендэрийн хөтөлбөртэй эхлүүлсэн хамтын ажиллагааг үргэлжлүүлж, парламентын өөрийн үнэлгээ, хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг хамтран зохион байгуулна.







## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



## VII БҮЛЭГ

---

### ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА

- 7.1. Захиргаа, хүний нөөцийн удирдлага
- 7.2. Албан хэрэг хөтлөлт, архив
- 7.3. Санхүүгийн удирдлага, дотоод аудит
- 7.4. Дүгнэлт, зорилт

## 7.1. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

### Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2022 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах ажлын

хүрээнд Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны өөрчлөлтийг хийв.

“**Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 144, 145 дугаар захирамжаар Тамгын газрын чиг үүрэг, бүтэц, орон тоог баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан.**

Улсын Их Хурлын цахим шилжилт, инновацыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Тамгын газрын чиг үүрэг, бүтцийн нэгжид өөрчлөлт оруулж, Мэдээллийн технологийн хэлтсийг “Цахим парламент, инновацын газар” болгон шинэчлэн зохион байгуулж, Мэдээллийн менежмент, дүн шинжилгээний албыг шинээр байгуулсан. Мэдээллийн менежмент, дүн шинжилгээний алба нь цахим парламентыг хөгжүүлэх бодлого, зохицуулалт, үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамжийн хэрэгцээг тодорхойлж, шинэ дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх, системийн хөгжүүлэлт, шинэчлэлтийг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэнэ.

Мөн Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд “Парламентын судалгааны хүрээлэн”-г чиг үүрэг, үйл ажиллагааны

үндсэн чиглэлтэй нь уялдуулан “Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн” болгож өөрчлөв.

Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн зарим нэгжүүдэд дотоод зохион байгуулалтын өөрчлөлт хийх замаар Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэст “Олон нийттэй харилцах алба”, Цахим парламент, инновацын газарт “Хуралдааны систем хариуцсан алба”, Захиргаа, хүний нөөцийн хэлтэст “Хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр хариуцсан алба”-ыг тус тус байгуулав.

Энэ нь Тамгын газрын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний 3.7.1-д заасан “Үр нөлөө бүхий парламентын мэргэшсэн ажлын албаны тогтолцоог хөгжүүлэх” зорилтын 3.7.1.1-д “... Тамгын газрын үйл ажиллагааны хүртээмжтэй, үр дүнтэй, мэргэшсэн байх шаардлагад нийцүүлэн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох” арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилттой уялдсан юм.

### Хүний нөөцийн удирдлага, нийгмийн баталгаа

2022 онд Улсын Их Хурлын Тамгын газар 206, Улсын Их Хурлын гишүүний ажлын алба 294, Улсын Их Хурлын даргын ажлын алба 19 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэв.

Тайлант хугацаанд Тамгын газрын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулахад онцгойлон

анхаарч ажиллалаа.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 488, 489 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын Тамгын газрын төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын 133 тодорхойлолтыг шинээр, шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулан баталсан.

Мөн Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 355 дугаар

захирамжаар “Улсын Их Хурлын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэв.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2019 оны 5 дугаар сарын

12-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Тамгын газарт өгсөн “Хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох дүрэм журмыг шинэчлэн батлах” чиглэлийн дагуу 2022 онд нийт 23 журмыг шинэчлэн баталж, мөрдөж байна.

**Шинэчлэн батлагдсан журамд Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Тамгын газрын бүтэц, чиг үүргийн дагуу зохих өөрчлөлтийг тусгаж, Тамгын газрын хэмжээнд дагаж мөрдөж байна.**


### Хүний нөөцийн судалгаа, мэдээлэл

2022 онд ажил, албан тушаалд шинээр томилогдсон 33, албан тушаалаас чөлөөлөгдсөн 25, дэвшин ажилласан 15, шилжин болон үргэлжлүүлэн ажилласан 36 албан хаагч байгаа бөгөөд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд

нийцүүлэн албан хаагчдын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг хийв.


Хүний нөөцийн хөдөлгөөн, чадавхыг нас, хүйс, мэргэжил, боловсрол, ажилласан жилийн үзүүлэлтээр дараах байдлаар харуулав.

### Хүний нөөцийн хөдөлгөөн



Тамгын газрын хүний нөөцийн төлөвлөлт, шилжилт хөдөлгөөнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тасралтгүй, шуурхай зохион байгуулснаар Улсын Их Хуралд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргээ хэвийн хэрэгжүүлэв.

### Насны ангилал



## Хүйсийн харьцаа



## Албан хаагчийн улсад ажилласан жил



Тамгын газрын нийт албан хаагчдын 27.6 хувь нь 10 хүртэл жил, 35.4 хувь нь 11-15 жил, 37 хувь нь улсад 21 ба түүнээс дээш жил ажиллаж буй албан хаагчид байна. Дээрх судалгаанаас үзвэл 72.4 хувь нь

улсад 11 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байгаа нь Тамгын газрын мэргэшсэн ажилтны нөөц өндөр түвшинд байгааг харуулж байна.

## Мэргэжлийн байдал



## Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ:

Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

2022 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулж, биелэлтийг хангаж ажилласан.

“ 2022 онд Улсын хоёрдугаар төв эмнэлэгт урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд 140 албан хаагч, Гепатит В вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх 3 тун дархлаажуулалтад 35 албан хаагч, улирлын томуугийн халдвараас сэргийлэх вакцинд 134 албан хаагчийг тус тус хамруулсан байна.

Мөн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу гэр бүлийн гишүүнээ асрах тэтгэх болон гачигдал тохиолдсон 22 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгож, 11 албан хаагчид өвлийн түлш худалдан авахад тусалцаа үзүүлэв.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 140 дүгээр захирамжаар 46 албан хаагчид ахлах түшмэлийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 42 дугаар зарлиг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 53 дугаар захирамжаар тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох шийдвэрийн дагуу Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 278 дугаар

захирамжаар тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг дэвийг 3 албан хаагчид, эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэрэг дэвийг 4 албан хаагчид олгохоор шийдвэрлэсний дагуу холбогдох шийдвэрийг гаргуулж, нэмэгдлийг олгуулах ажлыг зохион байгуулав.

### Төрийн дээд одон медаль, бусад шагналтны тоо




## 7.2. АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АРХИВ

2022 онд баримт бичиг зохион бүрдүүлэхээс бусад албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, бичиг хэргийн эргэлтэд тогтмол хяналт тавих механизмыг бий болгон Улсын Их Хурал, Тамгын газарт

ирсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, долоо хоног, сар бүр тогтмол тайлан мэдээ гаргаж, бичиг хэргийн эргэлтэд хяналт тавьж ажиллалаа.

### Баримт бичгийн эргэлт




Өмнөх онтой харьцуулахад 2022 онд Улсын Их Хуралд ирсэн бичиг 13.5 хувь, явуулсан бичиг 7.1 хувь тус тус буурч,

Тамгын газарт ирсэн бичиг 3.8 хувь, явуулсан бичиг 1.7 хувь, ирсэн өргөдөл, гомдол 31.4 хувиар өссөн байна.

## Архив

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдсөн баримтыг бүрэн бүрдүүлж,



Архивын бүрдүүлэлтийг 2021 онтой харьцуулбал цаасан суурьтай баримт 155 хадгаламжийн нэгж буюу 12.2 хувиар өссөн байна.

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын архивын үйл ажиллагааны журмыг шинээр батлагдсан хууль, журамд нийцүүлэн боловсруулж, Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 353 дугаар захирамжаар батлуулав. Уг журмаар архивын үйл ажиллагааг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид нийцүүлж, архивын бүрдүүлэлт, архивын

архивт хүлээлгэн өгөх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, дараах баримтаар сан хөмрөгийг баяжууллаа.

Үүнд:

Цаасан суурьтай 1274 хадгаламжийн нэгж;

Байнга хадгалах хадгаламжийн нэгж 860;

70 жил хадгалах хадгаламжийн нэгж 20;

Түр хадгалах хадгаламжийн нэгж 394;

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын, дэд, түр хорооны

2020 оны дүрс бичлэгийн blue-ray disc 109;

Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой гэрэл зургийн файл 66242.

үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх харилцааг нарийвчлан зохицуулсан болно.

“Улсын Их Хурал, түүний Тамгын газрын байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл. Данс-9. 2016-2020 он”-ийг боловсруулан, Тамгын газрын Баримт нягтлан шалгах комисс, Үндэсний төв архивын Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлж батлуулснаар Улсын Их Хурал, Тамгын газрын 2016-2020 оны архивын баримтыг бүрэн бүрдүүлж, бүртгэлийг албан ёсоор баталгаажууллаа.

## Архивын үйлчилгээ

2022 онд архивын үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдлыг хангахад анхааран ажиллаж 510 байгууллага, иргэн, албан хаагчдад 39,485 хуудас хуулбар олгон, 159 хэрэглэгчдэд 1060 хадгаламжийн нэгжийг ашиглуулсан

байна. Мөн 1990-2022 онд баталсан нийт 3876 хууль тогтоомжийн хувийн хэрэг бүхий цахим сан үүсгэн, файлын нэгдсэн сан <https://cloud.parliament.mn>-аар дамжуулан 55 хэрэглэгчид 85 хуулийн хувийн хэргийг цахимаар танилцуулсан.

## 7.3. САНХҮҮГИЙН УДИРДЛАГА, ДОТООД АУДИТ

Монгол Улсын Их Хурлын даргын Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд Монгол Улсын төсвөөс 2022 онд урсгал зардалд нийт 64,877.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 2,114.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан нь хууль тогтоох дээд байгууллагын хуулиар

хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болж төсвийн зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнг хуулийн дагуу тайлагнан ажилласан. 2022 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулахад 8.2 хувиар, төсвийн гүйцэтгэл өмнөх оноос 6.9 хувиар тус тус өссөн байна.

## Улсын Их Хурлын 2022 оны төсвийн гүйцэтгэл эх үүсвэрээр

(сая.төг)

Эдийн засгийн ангилал	Зардлын бүлэг	Батлагдсан төсөв		Төсвийн гүйцэтгэл		Төсвийн хэтрэлт, хэмнэлт	
		2021 он	2022 он	2021 он	2022 он	2021 он	2022 он
21	Урсгал зардал	58,337.1	64,877.7	56,939.9	62,426.2	1,397.2	2,451.4
22	Хөрөнгийн зардал	3,570.3	2,114.0	3,431.7	2,114.0	138.6	-
НИЙТ ЗАРДАЛ		61,907.4	66,991.7	60,371.6	64,540.3	1,535.8	2,451.4

2022 онд нийт батлагдсан төсвийн 54.3 хувь буюу 36.4 тэрбум төгрөг Улсын Их Хурлын гишүүдэд, 2.6 хувь буюу 1.7 тэрбум төгрөг Байнгын хороодод, 5.2 хувь буюу 3.5 тэрбум төгрөг Улсын Их Хурлын нийтлэг үйл ажиллагаа, 3.8 хувь буюу 2.6 тэрбум төгрөг Улсын Их Хурал дахь намын

бүлгүүдэд, 30.7 хувь буюу 20.5 тэрбум төгрөг Улсын Их Хурлын тамгын газарт, 0.2 хувь буюу 0.2 тэрбум төгрөг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд, 3.2 хувь буюу 2.1 тэрбум төгрөг хөрөнгө оруулалтад тус тус хуваарилагдсан байна.

## Улсын Их Хурлын төсвийн гүйцэтгэл төсвийн захирагчаар


(сая.төг)

Д/д	Нэгжийн нэр	Батлагдсан төсөв		Төсвийн гүйцэтгэл		Төсвийн хэтрэлт, хэмнэлт	
		2021 он	2022 он	2021 он	2022 он	2021 он	2022 он
1	УИХ-ын нийтлэг үйл ажиллагаа	4,158.1	3,482.1	4,118.0	3,252.4	40.1	229.7
2	УИХ-ын Тамгын газар	12,544.0	19,856.4	12,469.9	18,488.3	74.1	1,368.0
3	УИХ-ын даргын ажлын алба	619.6	682.0	693.3	784.0	-73.7	(102.0)
4	УИХ-ын гишүүд	36,524.4	36,376.9	35,099.6	35,540.3	1424.9	836.6
5	Байнгын хороод	2,079.0	1,736.0	2,029.0	1,703.2	50.1	32.8
6	УИХ дахь намын бүлгүүд	2,144.5	2,577.3	2,368.1	2,538.7	-223.6	38.6
7	Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	267.6	167.1	162.2	119.4	105.4	47.7
8	Хөрөнгө оруулалт	3,570.3	2,114.0	3,431.7	2,114.0	138.6	-
ДҮН		61,907.5	66,991.7	60,371.6	64,540.2	1535.9	2,451.4

Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны төсвийн нийт гүйцэтгэлийн 96.7 хувь буюу 62,426.2 сая төгрөг урсгал зардалд,

3.3 хувь буюу 2,114.0 сая төгрөг хөрөнгийн зардалд зарцуулагдсан байна.

## Төсвийн гүйцэтгэл шууд захирагчаар



Төсвийн зарцуулалтын 53.1% буюу 35.5 тэрбум төгрөг Улсын Их Хурлын гишүүд, 2.5% буюу 1.7 тэрбум төгрөг Байнгын хороод, 3.8% буюу 2.5 тэрбум төгрөг Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, 4.8% буюу 3.3 тэрбум төгрөг Улсын Их Хурлын нийтлэг үйл ажиллагаа, 28.8% буюу 19.3 тэрбум төгрөг Улсын Их Хурлын Тамгын

газар, 0.2% буюу 0.1 тэрбум төгрөг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, 3.1% буюу 2.1 тэрбум төгрөг хөрөнгө оруулалтад тус тус эзэлж байна.

Улсын Их Хурлын даргын 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэл 96.3 хувьтай байна.

### Батлагдсан төсвийн гүйцэтгэл хэтрэлт, хэмнэлт зардлын бүлгээр

(сая.төг)

Эдийн засгийн ангилал	Зардлын бүлэг	Батлагдсан төсөв		Төсвийн гүйцэтгэл		Төсвийн хэтрэлт, хэмнэлт	
		2021 он	2022 он	2021 он	2022 он	2021 он	2022 он
2101	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	24,422.9	26,555.1	23,706.3	25,239.3	716.6	1315.802
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	3,293.8	3,319.4	3,037.7	3,088.2	256.1	231.202
2104	Хангамж, бараа материалын зардал	1,393.1	1,089.6	1,388.6	946.7	4.5	142.879
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	145.2	50.4	143.5	50.4	1.7	0
2107	Томилолт, зочны зардал	1,867.5	2,192.8	1,819.4	2,171.2	48.1	21.528
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр, хураамж	3,794.5	8,234.6	3,783.9	8,226.8	10.5	7.837
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,568.6	21,680.8	21,562.2	21,661.3	6.3	19.477
2103	Урсгал шилжүүлэг	1,851.7	1,755.1	1,498.4	1,042.4	353.3	712.7
	ДҮН	58,337.1	64,877.7	56,939.9	62,426.2	1,397.2	2,451.4
2220	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,570.3	2,114.0	3,431.7	2,114.0	138.6	0
	НИЙТ ДҮН	61,907.4	66,991.7	60,371.6	64,540.2	1,535.8	2,451.4

### 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Улсын Их Хурлын даргын 2023 оны төсвийн төслийн нийт зардал 66,107.0 сая төгрөг, үүнээс урсгал зардал 66,007.0 сая төгрөг, хөрөнгийн зардал 0 төгрөг, өөрийн орлого 100.0 сая төгрөг байхаар төсөвлөн

батлагдсан. Урсгал зардал 1,229.3 сая төгрөгөөр нэмэгдэн, хөрөнгийн зардал 2,114.0 сая төгрөг буурсан, нийт жилийн төсөв өмнөх оны түвшингээс 884.7 сая төгрөг буюу 1.3 хувиар буурч батлагдсан.

### Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллав.

Урсгал зардлын 2.5 хувь буюу 1,547.0 сая төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 1.2 хувь буюу 712.7 сая төгрөгийн тэтгэмж, урамшууллын зардал, 0.2 хувь буюу 142.9 сая төгрөгийн хангамж, бараа материалын зардлууд тус тус хэмнэгдсэн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын гишүүнээр ажиллаж байгаа гишүүний цалингийн зардал хэмнэгдсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин



ашиглахыг хориглоно.” гэсэн заалтын дагуу албан тушаалын, албан ажлын дуудлагын унааг хязгаарлан, тээвэр шатахууны зардлыг хэмнэсэн.


Албан хаагчдад төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авах, гар утасны зардал, хэвлэлийн захиалгын төлбөр зэрэг зардлыг санхүүжүүлэх, зарцуулахыг хориглосон зохицуулалтын хүрээнд

сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх, нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй байх арга хэмжээг авч Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.


### Дотоод аудит, эрсдэлийн удирдлага

Тамгын газрын үйл ажиллагаанд хийх дотоод аудитын чиглэлээр 2022 онд 19 аудитын ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 21 аудитын ажлыг гүйцэтгэв. Гүйцэтгэсэн аудитыг аудитын төрлөөр ангилан үзвэл гүйцэтгэлийн аудит


-12, санхүүгийн аудит-3, нийцлийн аудит-5, санхүүгийн хяналт шалгалт-1 хийгдсэн байна. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын шийдвэрээр 5 сэдвийн хүрээнд тусгайлсан аудитыг гүйцэтгэв.




Гүйцэтгэлийн аудит



Нийцлийн аудит



Санхүүгийн аудит



Санхүүгийн хяналт, шалгалт

Тамгын газрын дотоод нэгжүүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлтэй хүчин зүйлийг илрүүлэн тогтоож, энэхүү эрсдэлийг бууруулах, эрсдэлийн эсрэг арга хэмжээ авах талаар холбогдох нэгжүүдэд зөвлөмж өгч ажиллав.

Дотоод аудитаар Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд илэрсэн зарим

зөрчил дутагдлуудыг холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, зөрчлийг арилгах, үйл ажиллагааг сайжруулах асуудлаар холбогдох нэгжүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

Дотоод аудитаар илэрсэн асуудал, зөрчлийг засуулах аудитын зөвлөмжийг боловсруулан, холбогдох газар, хэлтэст хүргүүлж, биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

### Тамгын газар “Эрсдэлийн удирдлагын бодлого”-оо батлав.

Улсын Их Хурлын Тамгын газар 2022 онд байгууллагын эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын төлөвшлийг шинэ шатанд гаргах бодлогын зорилт дэвшүүлсний үр дүнд “Улсын Их Хурлын Тамгын газрын Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг баталлаа.

Энэхүү Эрсдэлийн удирдлагын бодлогын зорилго нь Улсын Их Хурлын

Тамгын газраас хууль тогтоомжид заасан эрхлэх ажил, чиг үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдах, хариу арга хэмжээ авахад баримтлах зарчим, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход чиглэсэн болно.

## 7.4. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

### ПАРЛАМЕНТЫН МЭРГЭШСЭН АЖЛЫН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурлын цахим шилжилт, инновацыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Тамгын газрын үйл ажиллагааг хүртээмжтэй, үр дүнтэй, мэргэшсэн байх шаардлагад нийцүүлэн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож ажиллалаа.

Ийнхүү холбогдох хууль тогтоомжоор Тамгын газрын чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт орсон тул Тамгын газрын төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх нийт 133 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж, ажлын уялдаа холбоог сайжруулж, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгох арга хэмжээ авав.

2020 онд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос өгсөн Монгол Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөх нарийвчилсан дүрэм, журмыг баталж, мөрдүүлэх хүрээнд тайлант хугацаанд 23 журмыг шинээр болон шинэчлэн баталлаа. Ингэснээр Улсын Их Хурлаас хууль тогтоох, хянан шалгах, төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд зөвлөгөө, туслалцаа үзүүлэхэд шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэх ажил үр дүнд хүрэв.

Төсвийн ерөнхийлөн захирагч Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны батлагдсан төсвийн хүрээнд Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангах, санхүү, төсвийн удирдлагыг Улсын Их Хурлын тухай болон Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох бусад хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж, төсвийн ерөнхийлөн захирагч Монгол Улсын Их Хурлын даргын болон Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлгийг шаардлагатай мэдээ, тайлан, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тооцоо судалгаагаар шуурхай хангаж ажиллалаа.

Улсын Их Хурлын Тамгын газар 2022 онд байгууллагын эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын төлөвшлийг шинэ шатанд гаргах бодлогын зорилт дэвшүүлсний үр дүнд “Улсын Их Хурлын Тамгын газрын Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг батлан хэрэгжүүлж эхэллээ. Эрсдэлийн удирдлагын бодлого нь Улсын Их Хурлын Тамгын газраас хууль тогтоомжид заасан эрхлэх ажил, чиг үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдах, хариу арга хэмжээ авахад баримтлах зарчим, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон урт хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичиг болж байна.

Тамгын газар 2023 онд Улсын Их Хурлын захиргаа, санхүүгийн удирдлагын чиглэлээр дараах **“зорилт, арга хэмжээ”**-г хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

#### 1. Парламентын мэргэшсэн ажлын албаны чадавхыг бэхжүүлэх стратегийн хүрээнд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хоёр дахь шатыг эхлүүлнэ.

- 1.1. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хөтөлбөрт тусгагдсан ажилтны хөгжил, оролцоог дэмжихэд чиглэсэн бодлогын шинэлэг арга хэмжээний хэрэгжилтийг хангана.
- 1.2. Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчийн ёс зүйн сургалтын хөтөлбөрийн дагуу нийт ажилтнуудад зориулсан сургалтыг үе шаттай зохион байгуулж, ёс зүйн хэм хэмжээний онцлог, нийтлэг зарчим, албан үүргээ хариуцлагатай, төвийг сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, арга барил, чадварыг эзэмшүүлнэ.
- 1.3. Улсын Их Хурлын гишүүний ажлын албаны хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч- туслахад зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж, хэрэгжүүлнэ.

## **2. Төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт, дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ.**

- 2.1. Улсын Их Хурал, Тамгын газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үйл явцын үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан тэдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах нарийвчилсан төлөвлөгөө баталж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.
- 2.2. Тамгын газрын хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журмыг шинэчлэх ажлыг дуусгаж, шинээр болон шинэчлэн баталсан гурваас доошгүй журмын хэрэгжилтэд мониторинг хийж, гарч буй эерэг, сөрөг үр дагавар, үр нөлөөг судалж, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.
- 2.3. Тамгын газрын эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй зохион байгуулна.

## **3. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд цахим системийн хэрэглээг нэмэгдүүлж, санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлнэ.**

- 3.1. Үндсэн хөрөнгийн тооллогыг үндсэн хөрөнгө эзэмшигч албан хаагч өөрөө цахим системд бүртгүүлэн хийдэг аргыг хэвшүүлж, хөрөнгийн бүртгэлийн хяналтыг сайжруулна.
- 3.2. Төрийн сангийн удирдлагын төлбөр тооцооны цахим системийг үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн программтай интеграц хийнэ.

## **4. Дотоод аудитын олон улсын стандартыг хэрэгжүүлж, хараат бус бодитой баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагааны үр өгөөж, чанарыг сайжруулна.**

- 4.1. Дотоод аудитын хороо байгуулж, аудитын дүрмийг олон улсын стандартад нийцүүлэн шинээр боловсруулан батлуулж, аудитын засаглалыг сайжруулна.
- 4.2. Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын тогтолцоог шинээр бий болгож, аудитын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.
- 4.3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

